| 8               | 0-18 насны хүүхэд                                       | 618,269          | 15.9%         | 15,517.4        | 16.0%         |
| 9               | Төсөвт байгууллагын болон ААНБ-ын ажилтан               | 863,631          | 22.2%         | 23,353.7        | 24.1%         |
| 10              | Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч                    | 11,275           | 0.3%          | 256.8           | 0.3%          |
| 11              | Хүүхдээ асарч буй эх/эцэг                               | 202,399          | 5.2%          | 5,656.2         | 5.9%          |
| 12              | Бусад   | 24,578           | 0.6%          | 390.6           | 0.4%          |
| <b>Нийт дүн</b> |   | <b>3,896,017</b> | <b>100.0%</b> | <b>96,751.4</b> | <b>100.0%</b> |

Даатгуулагчийн төрлөөр авч үзвэл амбулаторийн тусламж, үйлчилгээний тохиолдлын 33.4 хувь, санхүүжилтийн 30.2 хувийг тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд, тохиолдлын 22.2 хувь, санхүүжилтийн 24.1 хувийг төсөвт байгууллагын болон ААНБ-ын ажилтан, тохиолдлын 15.9 хувь, санхүүжилтийн 16.0 хувийг 0-18 насны хүүхэд тус тус эзэлж байна.

Хүснэгт 14. Амбулаторийн тусламж, үйлчилгээний тохиолдол болон санхүүжилт, насны бүлгээр

| №               | Насны бүлэг     | Тохиолдол        |               | Санхүүжилт      |               |
|-----------------|-----------------|------------------|---------------|-----------------|---------------|
|                 |                 | тоо              | хувь          | сая төг         | хувь          |
| 1               | 00-04 нас       | 233,070          | 6.0%          | 5,473.68        | 5.7%          |
| 2               | 05-09 нас       | 160,848          | 4.1%          | 4,287.52        | 4.4%          |
| 3               | 10-14 нас       | 125,083          | 3.2%          | 3,262.21        | 3.4%          |
| 4               | 15-19 нас       | 156,373          | 4.0%          | 4,061.95        | 4.2%          |
| 5               | 20-24 нас       | 267,253          | 6.9%          | 6,932.13        | 7.1%          |
| 6               | 25-29 нас       | 342,445          | 8.8%          | 9,232.22        | 9.5%          |
| 7               | 30-34 нас       | 444,312          | 11.4%         | 10,576.05       | 10.9%         |
| 8               | 35-39 нас       | 367,509          | 9.4%          | 9,598.29        | 9.9%          |
| 9               | 40-44 нас       | 307,058          | 7.9%          | 7,706.39        | 8.0%          |
| 10              | 45-49 нас       | 304,053          | 7.8%          | 7,370.99        | 7.6%          |
| 11              | 50-54 нас       | 304,234          | 7.8%          | 7,221.63        | 7.5%          |
| 12              | 55-59 нас       | 295,414          | 7.6%          | 7,027.00        | 7.3%          |
| 13              | 60-64 нас       | 235,103          | 6.0%          | 5,619.54        | 5.8%          |
| 14              | 65-аас дээш нас | 353,263          | 9.1%          | 8,381.84        | 8.7%          |
| <b>Нийт дүн</b> |                 | <b>3,896,017</b> | <b>100.0%</b> | <b>96,751.4</b> | <b>100.0%</b> |

График 11. Амбулаторийн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо, насны бүлгээр



Амбулаторийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийг насны бүлгээр нь авч үзвэл 30-34 насны бүлэг хамгийн их буюу амбулаторийн тусламж, үйлчилгээний нийт тохиолдлын 11.4 хувийг, 10-14 насны бүлэг хамгийн бага буюу нийт тохиолдлын 3.2 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 15. **Амбулаторийн тусламж, үйлчилгээнд зонхилон тохиолдсон онош**

| №        | Олон улсын өвчний нэр   | Өвчний код | Тохиолдлын тоо |
|----------|---|------------|----------------|
| <b>1</b> | <b>Амбулаторийн тусламж, үйлчилгээ</b>                            |            |                |
| 1.1      | Өөр бүлэгт ангилсан өвчний шалтгаан болох коронавируст            | B97.2      | 244,021        |
| 1.2      | Өвчний зовиургүй, оношгүй хүмүүсийн бусад тусгай үзлэг, шинжилгээ | Z01        | 111,157        |
| 1.3      | Сувганцрын завсрын эдийн бусад архаг нефрит                       | N11        | 98,941         |
| 1.4      | Анхдагч даралт ихсэх өвчин  | I10        | 81,720         |
| 1.5      | Инсулинээс үл хамаарах чихрийн шижин, олон тооны хүндрэлтэй       | E11        | 63,753         |
| 1.6      | Гастрит ба дуоденит   | K29        | 63,370         |
| 1.7      | Зүрхний (хурмал) дутмагшилгүй даралт ихсэх өвчин                  | I11        | 48,235         |
| 1.8      | Мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэг                                | G54        | 47,274         |
| 1.9      | Зүрхний архаг ишемит өвчин  | I25        | 42,631         |
| 1.10     | Хамрын таславч муруйх   | J34.2      | 24,934         |
| <b>2</b> | <b>Амбулаторийн хяналт - Сэтгэцийн эмгэг</b>                      |            |                |
| 2.1      | Жор давтан олгох  | Z76.0      | 13,755         |
| 2.2      | Сэтгэц заслын дараах хяналтын үзлэг                               | Z09.3      | 11,834         |
| 2.3      | Хөдөлмөрийн чадвар алдагдсаны улмаас үйл ажиллагаа хязгаарлагдах  | Z73.6      | 1,228          |
| 2.4      | Өөр бүлэгт ангилаагүй бухимдал                                    | Z73.3      | 1,122          |
| 2.5      | Сэтгэц, зан төрхийн эмгэгийн сэжгээр ажиглалт хийх                | Z03.2      | 905            |
| <b>3</b> | <b>Амбулаторийн хяналт - Гэмтэл, осол</b>                         |            |                |
| 3.1      | Жор давтан олгох  | Z76.0      | 5,857          |
| 3.2      | Хугарлын эмчилгээний дараах хяналтын үзлэг                        | Z09.4      | 3,559          |
| 3.3      | Хугарлын ялтсан чиг ба бусад дотуур бэхлэх төхөөргийг авах        | Z47.0      | 914            |
| 3.4      | Хугарлын эмчилгээний дараа эдгэрэх                                | Z54.4      | 529            |
| 3.5      | Хавсарсан эмчилгээний дараа эдгэрэх                               | Z54.7      | 486            |
| <b>4</b> | <b>Амбулаторийн хяналт - Мэс заслын эмчилгээ</b>                  |            |                |
| 4.1      | Мэс заслын боолт ба оёдлын арчилгаа                               | Z48.0      | 61,327         |
| 4.2      | Мэс заслын дараах бусад тодорхой тусламж, үйлчилгээ               | Z48.8      | 10,756         |
| 4.3      | Бусад эмгэгийн мэс заслын дараах хяналтын үзлэг                   | Z09.0      | 6,550          |
| 4.4      | Жор давтан олгох  | Z76.0      | 5,845          |
| 4.5      | Мэс заслын дараа эдгэрэх  | Z54.0      | 5,613          |
| <b>5</b> | <b>Амбулаторийн хяналт - Халдварт бус өвчин</b>                   |            |                |
| 5.1      | Эрүүл мэндийн ерөнхий үзлэг                                       | Z00.0      | 107,331        |
| 5.2      | Хүүхдийн эрүүл мэндийн хэвшмэл үзлэг                              | Z00.1      | 25,520         |
| 5.3      | Жор давтан олгох  | Z76.0      | 6,949          |
| 5.4      | Бусад эмгэгийн бусад эмчилгээний дараах хяналтын үзлэг            | Z09.8      | 4,318          |

|           |   |       |        |
|-----------|---|-------|--------|
| 5.5       | Дотоод шүүрлийн суулгацтай байх   | Z96.4 | 3,038  |
| <b>6</b>  | <b>Амбулаторийн хяналт - Халдварт өвчин</b>                               |       |        |
| 6.1       | Жор давтан олгох  | Z76.0 | 6,684  |
| 6.2       | Бичил шинжүүрээр эерэг, цэрний өсгөвөртэй, буюу өсгөвөргүй уушгины сүрьеэ | A15.0 | 6,682  |
| 6.3       | Халдварт өвчин тээгч, тодорхойгүй   | Z22.9 | 5,792  |
| 6.4       | Бэлгийн замаар зонхилон дамжих халдвар тээгч                              | Z22.4 | 4,337  |
| 6.5       | Бактерсудлал ба эдсудлалын шинжилгээ сөрөг уушгины сүрьеэ                 | A16.0 | 3,800  |
| <b>7</b>  | <b>Амбулаторийн хяналт - Хорт хавдар</b>                                  |       |        |
| 7.1       | Жор давтан олгох  | Z76.0 | 6,122  |
| 7.2       | Хорт хавдрын хавсарсан эмчилгээний дараах хяналтын үзлэг                  | Z08.7 | 4,117  |
| 7.3       | Хорт хавдрын мэс заслын дараах хяналтын үзлэг                             | Z08.0 | 3,711  |
| 7.4       | Хорт хавдрын бусад эмчилгээний дараах хяналтын үзлэг                      | Z08.8 | 3,665  |
| 7.5       | Элэг шилжүүлэн суулгасантай холбоотой байдал                              | Z94.4 | 2,019  |
| <b>8</b>  | <b>Хэвийн явцтай жирэмсний хяналтын багц</b>                              |       |        |
| 8.1       | Бусад хэвийн жирэмсний хяналт   | Z34.8 | 40,814 |
| 8.2       | Хэвийн жирэмсний хяналт   | Z34   | 50,458 |
| 8.3       | Батлагдсан жирэмсэн   | Z32.1 | 15,297 |
| 8.4       | Хэвийн тулгар жирэмсний хяналт  | Z34.0 | 10,056 |
| 8.5       | Жирэмсний үзлэг ба сорил  | Z32   | 6,722  |
| <b>9</b>  | <b>Эрсдэлтэй жирэмсний хяналтын багц</b>                                  |       |        |
| 9.1       | Эрсдэл ихтэй жирэмсний хяналт   | Z35   | 74,519 |
| 9.2       | Жирэмсэн, төрөлттэй холбоотой бусад хуучтай жирэмсний хяналт              | Z35.2 | 35,953 |
| 9.3       | Бусад эрсдэл ихтэй жирэмсний хяналт                                       | Z35.8 | 23,499 |
| 9.4       | Эрсдэл ихтэй жирэмсний хяналт, тодорхойгүй                                | Z35.9 | 5,199  |
| 9.5       | Үр зулбах өгүүлэмжтэй эмэгтэйчүүдийн жирэмсний хяналт                     | Z35.1 | 3,277  |
| <b>10</b> | <b>Шүдний тусламж, үйлчилгээ</b>  |       |        |
| 10.1      | Сурвалжийн орой хэсгийн архаг периодонтит                                 | K04.5 | 43,590 |
| 10.2      | Тугалмайн цоорол  | K02.1 | 31,769 |
| 10.3      | Пульпит   | K04.0 | 28,543 |
| 10.4      | Ясжмагийн цоорол  | K02.2 | 19,793 |
| 10.5      | Шүдний паалангийн цоорол  | K02.0 | 13,499 |

## 2.2 ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭ

Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээнд арван төрлийн оношийн хамааралтай бүлгийн тусламж, үйлчилгээ багтдаг. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03-р тогтоол батлагдахаас өмнө төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын үзүүлсэн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний нэг тохиолдолд 160 мянган төгрөгийн санхүүжилт олгодог байсан бол 2021 оноос эхлэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулсан төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үзүүлсэн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний зардлын 70 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас, үлдэх 30 хувийг иргэн өөрөө хариуцан төлдөг болсон.

Улсын хэмжээнд хийгдсэн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний 145,931 тохиолдолд 14.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна.

Хүснэгт 16. Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт


| №               | Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ          | Тохиолдол      |               | Санхүүжилт      |               |
|-----------------|--|----------------|---------------|-----------------|---------------|
|                 |  | тоо            | хувь          | сая төг         | хувь          |
| 1               | Шинжилгээ                                    | 39,071         | 26.8%         | 2,082.7         | 14.7%         |
| 2               | КТ оношилгоо                                 | 35,266         | 24.2%         | 4,941.7         | 34.8%         |
| 3               | Зүрхний ЭХО, Холтер зүрхний цахилгаан бичлэг | 29,096         | 19.9%         | 1,252.4         | 8.8%          |
| 4               | Дурангийн оношилгоо                          | 26,079         | 17.9%         | 1,317.4         | 9.3%          |
| 5               | MRI оношилгоо                                | 14,296         | 9.8%          | 4,322.8         | 30.4%         |
| 6               | Дурангийн ажилбар                            | 851            | 0.6%          | 102.5           | 0.7%          |
| 7               | Электромиографи                              | 726            | 0.5%          | 72.7            | 0.5%          |
| 8               | Судасны бус ажилбар                          | 317            | 0.2%          | 76.1            | 0.5%          |
| 9               | Цөмийн оношилгоо                             | 213            | 0.1%          | 23.5            | 0.2%          |
| 10              | Судсан дотуур хийгдэх оношилгооны ажилбар    | 16             | 0.01%         | 7.3             | 0.1%          |
| <b>Нийт дүн</b> |  | <b>145,931</b> | <b>100.0%</b> | <b>14,199.1</b> | <b>100.0%</b> |

Өндөр өртөгтэй шинжилгээ нийт тохиолдлын 26.8 хувь, санхүүжилтийн 14.7 хувийг эзэлж байна. Харин өндөр өртөгтэй оношилгооны хувьд КТ оношилгоо нийт тохиолдлын 24.2 хувь, санхүүжилтийн 34.8 хувийг, дурангийн оношилгоо нийт тохиолдлын 19.9 хувь, санхүүжилтийн 8.8 хувийг зүрхний ЭХО, холтер зүрхний цахилгаан бичлэг, үлдэх хувийг бусад оношилгоо, шинжилгээ эзэлж байна.

Даатгуулагчийн төрлөөр нь авч үзвэл өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний нийт тохиолдлын 50 хувийг тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, 21 хувийг төсөвт байгууллага болон ААНБ-ын ажилтан, 9 хувийг шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэд, 20 хувийг бусад төрлийн даатгуулагчид эзэлж байна.

Насны бүлгээр авч үзвэл хамгийн их буюу нийт тохиолдлын 16.6 хувь, санхүүжилтийн 19.3 хувийг 65-аас дээш насны даатгуулагчид, харин тохиолдол болон санхүүжилтийн хувьд хамгийн бага хувийг 05-09 насны даатгуулагчид эзэлж байна.

График 12. Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний тохиолдлын тоо, санхүүжилт, насны бүлгээр, хувиар




Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний хамгийн их тохиолдолтой буюу 65-аас дээш нас болон 55-59 насны даатгуулагчдын үзүүлсэн оношилгоо, шинжилгээнд зүрхний ЭХО, холтер зүрхний цахилгаан бичлэг, КТ оношилгоо, шинжилгээ ихэнх хувийг эзэлж байна. MRI оношилгоо, дурангийн ажилбар, судсан дотуур хийгдэх оношилгооны ажилбар, судасны бус ажилбар, цөмийн оношилгоо, электромиографи зэрэг оношилгоо нийлээд 30 орчим хувийг эзэлж байна.

Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний нийт тохиолдлын 68.6 хувийг хамтын төлбөр төлөөгүй иргэд эзэлж байгаа бол 31.4 хувийг хамтын төлбөр төлсөн иргэд эзэлж байна. Үүнд хамтын төлбөр төлөөгүй иргэдэд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэн, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/, ял эдэлж байгаа ялтан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд багтаж байна.

## 2.3 ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд өдрийн эмчилгээ, үйлчилгээний 24,289 тохиолдолд 5.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна.

График 13. Өдрийн эмчилгээний санхүүжилт, тусламж, үйлчилгээний төрлөөр, хувиар





Өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 22.4 хувь, санхүүжилтийн 22.9 хувийг эзэлж байгаа бол өдрийн эмийн эмчилгээний тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 77.6 хувь, санхүүжилтийн 77.1 хувийг эзэлж байна.

Өдрийн эмчилгээг эмийн эмчилгээ болон мэс заслын тусламж, үйлчилгээ тус бүрээр зонхилон тохиолдох өвчлөлийг дараах байдлаар харууллаа.

**Хүснэгт 17. Өдрийн эмийн эмчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, зонхилон тохиолдох өвчлөлөөр**


| №               | Өдрийн эмийн эмчилгээ                                 | Тохиолдол     |               | Санхүүжилт    |               |
|-----------------|---|---------------|---------------|---------------|---------------|
|                 |   | тоо           | хувь          | сая төг       | хувь          |
| 1               | Анхдагч даралт ихсэх өвчин                            | 933           | 5.0%          | 223.6         | 5.5%          |
| 2               | Бүсэлхий-ууцны сүлжээний эмгэг                        | 594           | 3.2%          | 142.5         | 3.5%          |
| 3               | Сувганцрын завсрын эдийн архаг нефрит                 | 563           | 3.0%          | 134.7         | 3.3%          |
| 4               | Сувганцрын завсрын эдийн бусад архаг нефрит           | 512           | 2.7%          | 122.8         | 3.0%          |
| 5               | Мэдрэл сульдал  | 505           | 2.7%          | 121.2         | 2.9%          |
| 6               | Өөр бүлэгт ангилаагүй судасны шалтгаант толгой өвдөлт | 495           | 2.6%          | 118.5         | 2.9%          |
| 7               | Хүчдэлийн хэвшинжит толгой өвдөлт                     | 438           | 2.3%          | 104.9         | 2.6%          |
| 8               | Тархины судасны бусад тодорхой өвчин                  | 361           | 1.9%          | 86.6          | 2.1%          |
| 9               | Бусад архаг панкреатит                                | 346           | 1.8%          | 83.0          | 2.0%          |
| 10              | Толгой өвдөх бусад хамшинж                            | 339           | 1.8%          | 81.2          | 2.0%          |
| 11              | Архаг өнгөц гастрит                                   | 320           | 1.7%          | 76.7          | 1.9%          |
| 12              | Сөргөөтэй холбоотой бөглөрөлгүй архаг пиелонефрит     | 312           | 1.7%          | 75.3          | 1.8%          |
| 13              | Сувганцрын завсрын эдийн архаг нефрит, тодорхойгүй    | 247           | 1.3%          | 59.2          | 1.4%          |
| 14              | Архаг холецистит                                      | 240           | 1.3%          | 57.3          | 1.4%          |
| 15              | Инсулинээс үл хамаарах чихрийн шижин                  | 230           | 1.2%          | 55.2          | 1.3%          |
| 16              | Бусад дистони   | 202           | 1.1%          | 48.5          | 1.2%          |
| 17              | Дистони   | 199           | 1.1%          | 47.8          | 1.2%          |
| 18              | Зүрхний (хурмал) дутмагшилгүй даралт ихсэх өвчин      | 198           | 1.1%          | 47.4          | 1.1%          |
| 19              | Зүрхний архаг ишемит өвчин                            | 197           | 1.1%          | 47.1          | 1.1%          |
| 20              | Толгой өвдөх бусад тодорхой хамшинж                   | 162           | 0.9%          | 38.7          | 0.9%          |
| 21              | Бусад   | 11,334        | 60.5%         | 2326          | 56.9%         |
| <b>Нийт дүн</b> |   | <b>18,727</b> | <b>100.0%</b> | <b>4098.2</b> | <b>100.0%</b> |

Хүснэгт 18. Өдрийн мэс заслын тохиолдлын тоо болон санхүүжилт, зонхилон тохиолдох өвчлөлөөр

| №               | Өдрийн мэс засал                                   | Тохиолдол    |               | Санхүүжилт     |               |
|-----------------|--|--------------|---------------|----------------|---------------|
|                 |  | тоо          | хувь          | сая төг        | хувь          |
| 1               | Мөчний арьсны буглаа, хатиг ба мундас              | 834          | 15.0%         | 149.1          | 11.5%         |
| 2               | Арьсны буглаа, хатиг ба мундас                     | 723          | 13.0%         | 131.4          | 10.1%         |
| 3               | Өгзөгний арьсны буглаа, хатиг ба мундас            | 517          | 9.3%          | 92.3           | 7.1%          |
| 4               | Их биеийн арьсны буглаа, хатиг ба мундас           | 463          | 8.3%          | 82.1           | 6.3%          |
| 5               | Хамрын ясны хугарал                                | 198          | 3.6%          | 78.0           | 6.0%          |
| 6               | Хөхний үрэвсэлт өвчнүүд                            | 223          | 4.0%          | 58.3           | 4.5%          |
| 7               | Бусад байрлалт арьсны буглаа, хатиг ба мундас      | 260          | 4.7%          | 46.6           | 3.6%          |
| 8               | Өсөлтгүй жирэмсэн                                  | 225          | 4.0%          | 39.1           | 3.0%          |
| 9               | Хамрын таславч муруйх                              | 34           | 0.6%          | 30.0           | 2.3%          |
| 10              | Холбох ба бусад зөөлөн эдийн бусад хоргүй хавдар   | 117          | 2.1%          | 28.1           | 2.2%          |
| 11              | Хошноого ба шулуун гэдэс орчмын буглаа             | 83           | 1.5%          | 27.7           | 2.1%          |
| 12              | Өөхөн эдийн хоргүй хавдар                          | 77           | 1.4%          | 26.0           | 2.0%          |
| 13              | Хошногоны буглаа                                   | 68           | 1.2%          | 22.6           | 1.7%          |
| 14              | Эмнэлгийн үр хөндөлт                               | 118          | 2.1%          | 18.3           | 1.4%          |
| 15              | Хөхний өмөн  | 12           | 0.2%          | 16.8           | 1.3%          |
| 16              | Саатсан шүд  | 85           | 1.5%          | 16.6           | 1.3%          |
| 17              | Тунгалгийн булчирхайн хоёрдогч ба тодорхойгүй өмөн | 28           | 0.5%          | 16.4           | 1.3%          |
| 18              | Арьсны бусад өмөн                                  | 30           | 0.5%          | 16.0           | 1.2%          |
| 19              | Цавины ивэрхий                                     | 40           | 0.7%          | 15.1           | 1.2%          |
| 20              | Тромбоз бүхий далд шамбарам                        | 14           | 0.3%          | 14.6           | 1.1%          |
| 21              | Бусад  | 1,413        | 25.5%         | 372.1          | 28.8%         |
| <b>Нийт дүн</b> |  | <b>5,562</b> | <b>100.0%</b> | <b>1,297.2</b> | <b>100.0%</b> |


Өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээний хувьд арьсны идээт ба мөөгөнцөр өвчнүүд өндөр буюу нийт тохиолдлын 54.0 хувь, санхүүжилтийн 41.4 хувийг эзэлж байна.

График 14. Өдрийн эмчилгээний тохиолдол, сараар



Нийт тохиолдлын тоог сараар нь харахад өдрөөр үзүүлсэн тусламж, үйлчилгээний хамгийн өндөр буюу 17.5 хувийг 11 дүгээр сард даатгуулагчдад үзүүлсэн бол 6 дугаар сард нийт тохиолдлын 3.9 хувийг үзүүлсэн нь хамгийн бага байна.

График 15. Өдрийн эмчилгээ, даатгуулагчийн төрлөөр



Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцах төлдөг иргэд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, оюутнууд нийт тохиолдлын 33.1 хувийг эзэлж байна. Харин шимтгэлийг нь төр хариуцах иргэд (тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд, 0-18 насны хүүхэд, хүүхдээ харж буй эх/эцэг, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн) нийт тохиолдлын 66.9 хувь буюу хамгийн их хувийг эзэлж байна.


Хүснэгт 19. Өдрийн эмчилгээний тохиолдол болон санхүүжилт, даатгуулагчийн насны бүлгээр

| №               | Насны бүлэг | Тохиолдол     |               | Санхүүжилт     |               |
|-----------------|-------------|---------------|---------------|----------------|---------------|
|                 |             | тоо           | хувь          | сая төг        | хувь          |
| 1               | 00-04 нас   | 1,746         | 7.2%          | 250.0          | 4.6%          |
| 2               | 05-09 нас   | 941           | 3.9%          | 148.2          | 2.7%          |
| 3               | 10-14 нас   | 613           | 2.5%          | 99.3           | 1.8%          |
| 4               | 15-19 нас   | 538           | 2.2%          | 87.6           | 1.6%          |
| 5               | 20-24 нас   | 710           | 2.9%          | 118.1          | 2.2%          |
| 6               | 25-29 нас   | 1,195         | 4.9%          | 217.0          | 4.0%          |
| 7               | 30-34 нас   | 1,811         | 7.5%          | 291.7          | 5.4%          |
| 8               | 35-39 нас   | 2,093         | 8.6%          | 487.2          | 9.1%          |
| 9               | 40-44 нас   | 2,341         | 9.6%          | 554.4          | 10.3%         |
| 10              | 45-49 нас   | 2,742         | 11.3%         | 645.6          | 12.0%         |
| 11              | 50-54 нас   | 2,956         | 12.2%         | 783.4          | 14.5%         |
| 12              | 55-59 нас   | 2,445         | 10.1%         | 615.8          | 11.4%         |
| 13              | 60-64 нас   | 2,088         | 8.6%          | 549.1          | 10.2%         |
| 14              | 65-аас дээш | 2,070         | 8.5%          | 547.9          | 10.2%         |
| <b>Нийт дүн</b> |             | <b>24,289</b> | <b>100.0%</b> | <b>5,395.3</b> | <b>100.0%</b> |

Өдрийн мэс засал болон эмийн эмчилгээний хамгийн их буюу нийт тохиолдлын 15.8 хувийг, санхүүжилтийн 10.8 хувийг 0-19 насны даатгуулагч, мөн тэтгэврийн насны хүн ам буюу 55-аас дээш насныхан нийт тохиолдлын 27.2 хувийг, санхүүжилтийн 31.8 хувийг эзэлж байна.

Өдрийн эмчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн хариуцдаг бөгөөд даатгуулагч ямар нэгэн хамтын төлбөр төлөхгүйгээр дээрх тусламж, үйлчилгээг авч байна. Энэ нь иргэдийг эрүүл мэндийн шаардлагатай тусламж, үйлчилгээгээ өдрийн эмчилгээгээр авах сонирхлыг төрүүлж, шаардлагагүй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоог багасгаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.


График 16. Өдрийн эмийн болон мэс заслын эмчилгээ, даатгуулагчийн насаар



Эндээс харахад өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээг бага насны хүүхдүүд түлхүү авсан бол нас нэмэгдэх тусам эзлэх хувь нь буурсан байна. Энэ нь бага насны хүүхдүүдийн дунд арьсны идээт ба мөөгөнцөрт өвчнүүд, хошноого, шулуун гэдэс, гэдэсний буглаа зэрэг өвчлөл өндөр байна гэж үзэж болохоор байна.

Харин өдрийн эмийн эмчилгээний тусламж, үйлчилгээг насанд хүрэгсэд түлхүү авдаг бөгөөд нас нэмэгдэх тусам эзлэх хувь нь ихэсч байгаа нь зүрх, судасны өвчлөл, бөөр шээсний замын өвчлөл, мэдрэлийн гаралтай өвчлөл, хоол боловсруулах замын өвчлөл их байгаатай холбоотой байна.

График 17. Өдрийн эмчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, аймгаар



Өдрийн эмчилгээг аймаг, нийслэлээр нь авч үзэхэд Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагууд нийт тохиолдлын 52.0 хувь, санхүүжилтийн 50.3 хувийг авсан бол орон нутгаас Ховд, Дорнод, Дорноговь, Хэнтий аймгуудын эрүүл мэндийн байгууллагууд бусад аймгуудаас өндөр дүнтэй санхүүжилт авсан байна.

Энэ нь газар нутгийн хувьд алслагдсан аймгуудын хүн ам тухайн орон нутагтаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түлхүү авч байгаатай холбоотой байна.

## 2.4 ХОРТ ХАВДРЫН ХИМИЙН БОЛОН ТУЯАНЫ ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ


Эрүүл мэндийн даатгалын сангаас хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээний 17,452 тохиолдолд 12.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна.

Хүснэгт 20. Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээний тохиолдлын тоо, санхүүжилт

| №               | Өдрийн эмчилгээ              | Тохиолдол     |               | Санхүүжилт      |               |
|-----------------|------------------------------|---------------|---------------|-----------------|---------------|
|                 |                              | тоо           | хувь          | сая төг         | хувь          |
| 1               | Хорт хавдрын туяа эмчилгээ   | 11,887        | 68.1%         | 3,552.2         | 28.7%         |
| 2               | Хорд хавдрын химийн эмчилгээ | 5,565         | 31.9%         | 8,935.2         | 71.3%         |
| <b>Нийт дүн</b> |                              | <b>17,452</b> | <b>100.0%</b> | <b>12,387.4</b> | <b>100.0%</b> |


Нийт тохиолдлын 68.1 хувийг хорт хавдрын туяа эмчилгээ эзэлж байгаа бол санхүүжилтийн 71.1 хувийг хими эмчилгээ эзэлж байна. Үүнээс үзэхэд хорт хавдрын туяа эмчилгээ нь тохиолдлын тоогоор их боловч нэгж тохиолдлын өртөг нь бага, харин хими эмчилгээ нь тохиолдлын тоогоор бага боловч нэгж тохиолдлын өртөг өндөр байгаа нь харагдаж байна.

График 18. Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээний тохиолдол, сараар



Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээний тохиолдлын тоог сараар нь авч үзвэл 3 болон 7 сард хамгийн их тусламж, үйлчилгээ авсан бол 12 сард хамгийн бага байна.

График 19. Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээний тохиолдол, даатгуулагчийн төрлөөр



Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээний нийт тохиолдлын 86.9 хувийг, бусад даатгуулагчид 13.1 хувийг эзэлж байна. Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд гэдэгт эрэгтэй 60, эмэгтэй 55 болон түүнээс дээш настай иргэн, 16 насанд хүрсэн одой иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 18 хүртэлх насны дөрөв болон түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг ордог.

Хүснэгт 21. Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээний тохиолдол, даатгуулагчийн насны бүлгээр

| №               | Насны бүлэг | Тохиолдол     |               | Санхүүжилт      |               |
|-----------------|-------------|---------------|---------------|-----------------|---------------|
|                 |             | тоо           | хувь          | сая төг         | хувь          |
| 1               | 00-04 нас   | 78            | 0.4%          | 38.7            | 0.3%          |
| 2               | 05-09 нас   | 175           | 1.0%          | 72.2            | 0.6%          |
| 3               | 10-14 нас   | 130           | 0.7%          | 49.5            | 0.4%          |
| 4               | 15-19 нас   | 77            | 0.4%          | 22.8            | 0.2%          |
| 5               | 20-24 нас   | 52            | 0.3%          | 34.6            | 0.3%          |
| 6               | 25-29 нас   | 343           | 2.0%          | 181.5           | 1.5%          |
| 7               | 30-34 нас   | 657           | 3.8%          | 374.1           | 3.0%          |
| 8               | 35-39 нас   | 1,303         | 7.5%          | 1,167.8         | 9.4%          |
| 9               | 40-44 нас   | 1,674         | 9.6%          | 1,197.6         | 9.7%          |
| 10              | 45-49 нас   | 2,480         | 14.2%         | 1,817.9         | 14.7%         |
| 11              | 50-54 нас   | 2,352         | 13.5%         | 1,727.1         | 13.9%         |
| 12              | 55-59 нас   | 2,701         | 15.5%         | 1,958.8         | 15.8%         |
| 13              | 60-64 нас   | 2,513         | 14.4%         | 1,875.9         | 15.1%         |
| 14              | 65-аас дээш | 2,917         | 16.7%         | 1,868.9         | 15.1%         |
| <b>Нийт дүн</b> |             | <b>17,452</b> | <b>100.0%</b> | <b>12,387.4</b> | <b>100.0%</b> |

Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээний нийт тохиолдлын 60.1 хувь, санхүүжилтийн 60.0 хувийг 50-аас дээш насны даатгуулагчдад үзүүлсэн байна.

Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн хариуцдаг бөгөөд даатгуулагч ямар нэгэн хамтын төлбөр төлөхгүйгээр тусламж, үйлчилгээг авч байна. Энэхүү бодлогын арга хэмжээ нь хорт хавдраар өвдсөн иргэдийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн хүндрэлд орохоос сэргийлж байна.

## 2.5 ДИАЛИЗЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Диализын тусламж, үйлчилгээнд гемодиализ болон хэвлийн диализын тусламж, үйлчилгээ ордог бөгөөд өнгөрсөн онд 155,983 тохиолдолд 16.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна.

Улсын хэмжээнд 2021 онд 47 эрүүл мэндийн байгууллагад диализын тусламж, үйлчилгээ үзүүлсний хамгийн ихийг буюу 24 хувийг Улсын нэгдүгээр төв эмнэлэг, хамгийн бага буюу 0.01 хувийг Завхан аймгийн Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төв үзүүлсэн.

Диализын тусламж, үйлчилгээний нийт тохиолдолын 72.0 хувь, санхүүжилтийн 85.4 хувийг гемодиализын тусламж, үйлчилгээ, тохиолдлын 28.0 хувь, санхүүжилтийн 14.6 хувийг хэвлийн диализ эзэлж байна.

**Хүснэгт 22. Диализын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо, санхүүжилт, тусламж, үйлчилгээний төрлөөр**

| №               | Тусламж, үйлчилгээний төрөл | Тохиолдол      |               | Санхүүжилт      |               |
|-----------------|-----------------------------|----------------|---------------|-----------------|---------------|
|                 |                             | тоо            | хувь          | сая төг         | хувь          |
| 1               | Гемодиализ                  | 112,278        | 72.0%         | 13,721.1        | 85.4%         |
| 2               | Хэвлийн диализ              | 43,705         | 28.0%         | 2,338.7         | 14.6%         |
| <b>Нийт дүн</b> |                             | <b>155,983</b> | <b>100.0%</b> | <b>16,059.8</b> | <b>100.0%</b> |


Даатгуулагчийн төрлөөр нь авч үзвэл диализын тусламж, үйлчилгээний 97.1 хувийг тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд, үлдсэн 2.9 хувийг бусад даатгуулагчдад үзүүлж байна.

**Хүснэгт 23. Диализын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, даатгуулагчийн төрлөөр**

| №               | Даатгуулагчийн төрөл   | Тохиолдол      |               | Санхүүжилт      |               |
|-----------------|--|----------------|---------------|-----------------|---------------|
|                 |  | тоо            | хувь          | сая төг         | хувь          |
| 1               | Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн  | 151,396        | 97.1%         | 15,526.9        | 96.7%         |
| 2               | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд                                | 1,979          | 1.2%          | 237.8           | 1.5%          |
| 3               | Төсөвт байгууллагын болон ААНБ-ын ажилтан  | 1,221          | 0.8%          | 123.8           | 0.8%          |
| 4               | 0-18 насны хүүхэд  | 712            | 0.5%          | 88.7            | 0.5%          |
| 5               | Шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэд  | 669            | 0.4%          | 81.7            | 0.5%          |
| 6               | Бусад (хүүхдээ асарч буй эх/эцэг, ял эдэлж байгаа ялтан, хугацаат цэргийн албан хаагч) | 6              | 0.004%        | 0.6             | 0.004%        |
| <b>Нийт дүн</b> |  | <b>155,983</b> | <b>100.0%</b> | <b>16,059.8</b> | <b>100.0%</b> |

Диализын тусламж, үйлчилгээний нийт санхүүжилтийн 89.5 хувийг 30-с дээш насныхан, 10.5 хувийг 30 хүртэлх насныхан эзэлж байгаа бол хамгийн их санхүүжилт нь 50-54 насны даатгуулагчийн тусламж, үйлчилгээнд зарцуулагдсан байна.

График 20. Диализын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, насны бүлгээр



Диализын тусламж, үйлчилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь санхүүжүүлдэг бөгөөд даатгуулагч ямар нэгэн хамтын төлбөр төлөхгүйгээр өөрт ойрхон байгаа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн мэндийн байгууллагаас диализын тусламж, үйлчилгээг авдаг болно.

## 2.6 ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нийт 391,399 тохиолдолд 324.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. Үүнээс, эмийн эмчилгээ нийт тохиолдлын 75.9 хувь, санхүүжилтийн 51.4 хувийг, мэс заслын тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 21.2 хувь, санхүүжилтийн 39.3 хувийг тус тус эзэлж байгаа нь бусад төрлийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээтэй харьцуулахад өндөр дүнтэй байна.


Хүснэгт 24. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт

| №               | Тусламж, үйлчилгээний төрөл                       | Тохиолдол      |               | Санхүүжилт       |               |
|-----------------|---|----------------|---------------|------------------|---------------|
|                 |   | тоо            | хувь          | сая төг          | хувь          |
| 1               | Мэс засал   | 82,666         | 21.2%         | 128,293.9        | 39.5%         |
| 2               | Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ | 3,689          | 0.9%          | 6,233.3          | 1.9%          |
| 3               | Эмийн эмчилгээ                                    | 297,251        | 75.9%         | 166,884.3        | 51.4%         |
| 4               | Эрхтэн шилжүүлэх мэс засал                        | 46             | 0.01%         | 4,056.8          | 1.2%          |
| 5               | Эрчимт эмчилгээ                                   | 7,747          | 2.0%          | 19,458.2         | 6.0%          |
| <b>Нийт дүн</b> |   | <b>391,399</b> | <b>100.0%</b> | <b>324,926.5</b> | <b>100.0%</b> |



Аймаг, нийслэлээр задалж харахад хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нийт тохиолдлын 58.6 хувь буюу 228.3 мянган тохиолдлыг, нийт санхүүжилтийн 71.0 хувь буюу 230.9 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг эрүүл мэндийн байгууллагууд, үлдэх хувийн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд үзүүлсэн байна. 21 аймгийн хувьд тохиолдлын тоо болон санхүүжилтийн дүнгээр Орхон, Дархан-Уул, Хөвсгөл, Баян-Өлгий аймгууд хамгийн өндөр гүйцэтгэлтэй гарсан байна.

График 21. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, аймгаар



Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагуудыг төрлөөр нь авч үзвэл нийт тохиолдлын 72.7 хувь буюу 284,985 тохиолдлын тусламж, үйлчилгээг төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагууд үзүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас 242.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан бол 26.8 хувь буюу 104,801 тохиолдлын тусламж, үйлчилгээг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд үзүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас 82.2 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна. Үлдэх хувийг рашаан сувилалууд болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа эрүүл мэндийн байгууллагууд эзэлж байна.

Хүснэгт 25. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт хувиар, ЭМБ-ын төрлөөр

| №               | ЭМБ-ын төрөл         | Тохиолдол      |               | Санхүүжилт       |               |
|-----------------|----------------------|----------------|---------------|------------------|---------------|
|                 |                      | тоо            | хувь          | сая төг          | хувь          |
| 1               | Хувийн эмнэлэг       | 104,801        | 26.8%         | 82,155.8         | 25.3%         |
| 2               | Төрийн өмчит ЭМБ-ууд | 284,985        | 72.7%         | 241,981.3        | 74.4%         |
| 3               | Рашаан сувилал       | 199            | 0.1%          | 273.2            | 0.1%          |
| 4               | ШШГЕГ                | 1,414          | 0.4%          | 516.2            | 0.2%          |
| <b>Нийт дүн</b> |                      | <b>391,399</b> | <b>100.0%</b> | <b>324,926.5</b> | <b>100.0%</b> |


Эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлыг эрүүл мэндийн даатгалд даатгуулсан даатгуулагчдын төрлөөр авч үзвэл нийт тохиолдлын 37.9 хувийг тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд, 17.5 хувийг төсөвт байгууллагын болон ААНБ-ын ажилтан, 15.4 хувийг 0-18 насны хүүхэд, 13.7 хувийг Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд тус тус эзэлж байгаа нь бусад даатгуулагчдаас илүү хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг

авсан байна. Харин санхүүжилтийн хувьд авч үзэхэд нийт санхүүжилийн 48.6 хувийг тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардал хамгийн өндөр дүнг эзэлж байна.

**Хүснэгт 26. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, даатгуулагчийн төрлөөр**

| №               | Даатгуулагчийн төрөл                                    | Тохиолдол      |               | Санхүүжилт       |               |
|-----------------|---|----------------|---------------|------------------|---------------|
|                 |   | тоо            | хувь          | сая төг          | хувь          |
| 1               | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд | 53,523         | 13.7%         | 35,887.2         | 11.0%         |
| 2               | Гадаадын иргэн, харьяалалгүй                            | 26             | 0.007%        | 10.1             | 0.003%        |
| 3               | Малчин  | 6,406          | 1.6%          | 4,396.0          | 1.3%          |
| 4               | Оюутан, суралцагч                                       | 2,277          | 0.6%          | 1,490.0          | 0.5%          |
| 5               | Шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэд                   | 22,599         | 5.8%          | 17,250.3         | 5.3%          |
| 6               | Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн                   | 148,456        | 37.9%         | 157,855.2        | 48.6%         |
| 7               | Ял эдэлж байгаа ялтан                                   | 673            | 0.2%          | 341.4            | 0.1%          |
| 8               | 0-18 насны хүүхэд                                       | 60,269         | 15.4%         | 44,410.4         | 13.7%         |
| 9               | Төсөвт байгууллагын болон ААНБ-ын ажилтан               | 68,652         | 17.5%         | 47,037.9         | 14.5%         |
| 10              | Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч                    | 422            | 0.1%          | 361.7            | 0.1%          |
| 11              | Хүүхдээ асарч буй эх/эцэг                               | 28,096         | 7.2%          | 15,886.4         | 4.9%          |
| <b>Нийт дүн</b> |   | <b>391,399</b> | <b>100.0%</b> | <b>324,926.5</b> | <b>100.0%</b> |

График 22. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо, даатгуулагчийн төрлөөр



Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авсан хүн амыг насны бүлгээр авч үзэхэд 0-19 насны болон 65-аас дээш насны даатгуулагчдад үзүүлсэн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний 121,991 тохиолдолд 107.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон нь бусад насны бүлгээс хамгийн өндөр дүнтэй байна.

**Хүснэгт 27. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, даатгуулагчийн насны бүлгээр**

| №               | Даатгуулагчийн насны бүлгээр | Тохиолдол      |               | Санхүүжилт       |               |
|-----------------|------------------------------|----------------|---------------|------------------|---------------|
|                 |                              | тоо            | хувь          | сая төг          | хувь          |
| 1               | 00-04 нас                    | 34,843         | 8.9%          | 25,018.8         | 7.7%          |
| 2               | 05-09 нас                    | 9,882          | 2.5%          | 8,290.6          | 2.6%          |
| 3               | 10-14 нас                    | 9,321          | 2.4%          | 6,961.9          | 2.1%          |
| 4               | 15-19 нас                    | 10,969         | 2.8%          | 7,825.5          | 2.4%          |
| 5               | 20-24 нас                    | 24,095         | 6.2%          | 15,289.2         | 4.7%          |
| 6               | 25-29 нас                    | 32,855         | 8.4%          | 20,818.2         | 6.4%          |
| 7               | 30-34 нас                    | 40,440         | 10.3%         | 27,383.8         | 8.4%          |
| 8               | 35-39 нас                    | 35,009         | 8.9%          | 25,850.8         | 8.0%          |
| 9               | 40-44 нас                    | 27,475         | 7.0%          | 22,525.6         | 6.9%          |
| 10              | 45-49 нас                    | 25,484         | 6.5%          | 22,751.4         | 7.0%          |
| 11              | 50-54 нас                    | 26,434         | 6.8%          | 24,337.4         | 7.5%          |
| 12              | 55-59 нас                    | 29,745         | 7.6%          | 29,394.9         | 9.1%          |
| 13              | 60-64 нас                    | 27,871         | 7.1%          | 29,298.6         | 9.0%          |
| 14              | 65-аас дээш нас              | 56,976         | 14.6%         | 59,179.7         | 18.2%         |
| <b>Нийт дүн</b> |                              | <b>391,399</b> | <b>100.0%</b> | <b>324,926.5</b> | <b>100.0%</b> |


Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нийт тохиолдлын 75.9 хувь, санхүүжилтийн 51.4 хувийг эмийн эмчилгээ, харин мэс заслын тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 21.1 хувь, санхүүжилтийн 39.5 хувийг тус тус эзэлж байгаа нь бусад төрлийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

**Хүснэгт 28. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний нэр төрлөөр**

| №               | Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний төрөл      | Тохиолдол      |               | Санхүүжилт       |               |
|-----------------|---|----------------|---------------|------------------|---------------|
|                 |   | тоо            | хувь          | сая төг          | хувь          |
| 1               | Мэс засал   | 82,666         | 21.1%         | 128,293.9        | 39.5%         |
| 2               | Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ | 3,689          | 0.9%          | 6,233.3          | 1.9%          |
| 3               | Эмийн эмчилгээ                                    | 297,251        | 75.9%         | 166,884.3        | 51.4%         |
| 4               | Эрхтэн шилжүүлэх мэс засал                        | 46             | 0.01%         | 4,056.8          | 1.2%          |
| 5               | Эрчимт эмчилгээ                                   | 7,747          | 2.0%          | 19,458.2         | 6.0%          |
| <b>Нийт дүн</b> |   | <b>391,399</b> | <b>100.0%</b> | <b>324,926.5</b> | <b>100.0%</b> |

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг насны бүлгээр задалж авч үзэхэд 0-19 насны даатгуулагчдын эрчимт эмчилгээний зардал бусад насны бүлгээс өндөр байна. 25 наснаас эхлэн даатгуулагчийн эмийн эмчилгээний зардал буурч, харин мэс заслын болон эрчимт эмчилгээний зардал нэмэгдэх хандлагатай байна. Мөн энэ наснаас эхлэн хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээний зардал нас ахих тусам нэмэгдэж байна. Харин эрхтэн шилжүүлэх мэс заслын санхүүжилтийн хувьд 40-44 насны болон 50-54 насны бүлгийн даатгуулагчид бусад насны бүлгээс түлхүү эрхтэн шилжүүлэх мэс засалд орсон байна.

График 23. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний санхүүжилт, тусламж, үйлчилгээний нэр төрлөөр, насны бүлгээр



Тусламж, үйлчилгээний таван үндсэн нэр төрөл тус бүрээр зонхилон тохиолдох тусламж, үйлчилгээг задалж үзэхэд эрүүл мэндийн байгууллагуудад дараах оношийн бүлгүүдээр хамгийн их санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 29. Тусламж, үйлчилгээний төрөл тус бүрээрх зонхилон тохиолдох оношийн хамааралтай бүлгийн тохиолдлын тоо болон санхүүжилт

| №        | Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний төрлөөр                         | Тохиолдол      |              | Санхүүжилт       |              |
|----------|--|----------------|--------------|------------------|--------------|
|          |  | тоо            | хувь         | сая төг          | хувь         |
| <b>1</b> | <b>Мэс засал</b>   | <b>82,666</b>  | <b>21.1%</b> | <b>128,293.9</b> | <b>39.5%</b> |
| 1.1      | Цочмог аппендицит  | 8,257          | 10.0%        | 4,400.4          | 3.4%         |
| 1.2      | Цөсний чулуу, холецистит   | 6,674          | 8.1%         | 6,107.0          | 4.8%         |
| 1.3      | Болрын цийлт   | 3,987          | 4.8%         | 10,026.1         | 7.8%         |
| 1.4      | Үр хөндөлт, умайн гаднах жирэмсэн ба цулцан хураатай холбоотой хүндрэл | 3,864          | 4.7%         | 1,562.0          | 1.2%         |
| 1.5      | Хамрын таславчийн эмгэг  | 3,201          | 3.9%         | 4,471.1          | 3.5%         |
| 1.6      | Бусад  | 56,683         | 68.5%        | 101,727.2        | 79.3%        |
| <b>2</b> | <b>Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ</b>               | <b>3,689</b>   | <b>0.9%</b>  | <b>6,233.3</b>   | <b>1.9%</b>  |
| 2.1      | Хавдрын дараах хими эмчилгээ   | 3,053          | 82.8%        | 3,414.9          | 54.8%        |
| 2.2      | Хавдрын дараах химийн бай эмчилгээ                                     | 636            | 17.2%        | 2,818.4          | 45.2%        |
| <b>3</b> | <b>Эмийн эмчилгээ</b>  | <b>297,251</b> | <b>75.9%</b> | <b>166,884.3</b> | <b>51.4%</b> |
| 3.1      | Нэг ургийн хэвийн төрлөг   | 35,309         | 11.9%        | 17,836.9         | 10.7%        |
| 3.2      | Сувганцрын завсрын эдийн өвчнүүд                                       | 22,743         | 7.7%         | 15,866.4         | 9.5%         |
| 3.3      | Амьсгалын тогтолцооны бусад өвчнүүд                                    | 16,599         | 5.6%         | 3,887.7          | 2.3%         |
| 3.4      | Хоол боловсруулах тогтолцооны бусад өвчнүүд                            | 15,581         | 5.2%         | 3,665.3          | 2.2%         |
| 3.5      | Кесар хагалгаагаар нэг болон ихэр ургийг төрүүлэх                      | 14,299         | 4.8%         | 10,092.6         | 6.0%         |
| 3.6      | Бусад  | 192,720        | 64.8%        | 115,535          | 69.2%        |

|                 |                                       |                |               |                  |               |
|-----------------|---------------------------------------|----------------|---------------|------------------|---------------|
| <b>4</b>        | <b>Эрхтэн шилжүүлэх мэс засал</b>     | <b>46</b>      | <b>0.01%</b>  | <b>4,056.8</b>   | <b>1.2%</b>   |
| 4.1             | Элэгний фиброз ба цирроз              | 21             | 45.7%         | 2,329.1          | 57.4%         |
| 4.2             | Элэгний фиброз                        | 7              | 15.2%         | 738.6            | 18.2%         |
| 4.3             | Бөөрний архаг дутмагшил               | 6              | 13.0%         | 146.3            | 3.6%          |
| 4.4             | Бөөрний өвчний төгсгөлийн шат         | 5              | 10.9%         | 120.8            | 3.0%          |
| 4.5             | Элэг ба элгэн дэх цэсний сувгийн өмөн | 3              | 6.5%          | 312.4            | 7.7%          |
| 4.6             | Бусад                                 | 4              | 8.7%          | 409.6            | 10.1%         |
| <b>5</b>        | <b>Эрчимт эмчилгээ</b>                | <b>7,747</b>   | <b>2.0%</b>   | <b>19,458.2</b>  | <b>6.0%</b>   |
| 5.1             | Нярайн ишемийн шалтгаант энцефалопати | 532            | 6.9%          | 1,708.3          | 8.8%          |
Хүүхдийн зүрхний төрөлхийн гажиг засах мэс засалд эрүүл мэндийн даатгалын сангаас 3 сая төгрөг олгож байсныг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03-р тогтоолоор 8.0 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн. Өнгөрсөн онд 0-19 насны 213 даатгуулагчдад зүрхний төрөлхийн гажиг засах мэс засал хийж, 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. Энэхүү мэс заслын нийт тохиолдлын 68.5 хувийг 0-4 нас, 23.9 хувийг 5-9 нас, үлдэх хувийг 10-19 насныхан эзэлж байна. Төрөлхийн гажиг засах мэс заслын тусламж, үйлчилгээний нийт тохиолдлын 75.6 хувь, санхүүжилтийн 79.1 хувийг Улаанбаатар Сонгдо эмнэлэг, тохиолдлын 17.8 хувь, санхүүжилтийн 18.4 хувийг Улсын гуравдугаар төв эмнэлэг, үлдэх хувийг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв үзүүлсэн байна.

**Хүснэгт 54. Хүүхдийн зүрхний төрөлхийн гажиг засах мэс заслын тохиолдлын тоо, насны бүлгээр, хувиар**

| №           | Насны бүлэг | Тохиолдол  |               | Санхүүжилт     |               |
|-------------|-------------|------------|---------------|----------------|---------------|
|             |             | тоо        | хувь          | сая төг        | хувь          |
| 1           | 00-04 нас   | 146        | 68.5%         | 1,083.5        | 67.5%         |
| 2           | 05-09 нас   | 51         | 23.9%         | 393.3          | 24.5%         |
| 3           | 10-14 нас   | 10         | 4.7%          | 79.8           | 5.0%          |
| 4           | 15-19 нас   | 6          | 2.9%          | 47.9           | 3.0%          |
| <b>Нийт</b> |             | <b>213</b> | <b>100.0%</b> | <b>1,604.5</b> | <b>100.0%</b> |

Харин хүүхдийн биеийн олон хэсгийн түлэнхийн мэс заслын тусламж, үйлчилгээний 8 оношийн бүлгийн 155 тохиолдолд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна. Түлэнхийн мэс заслын нийт тохиолдлын 30.2 хувь, санхүүжилтийн 64.9 хувийг Биеийн олон хэсэг халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх мэс заслын хагалгаа, нийт тохиолдлын 24.2 хувь, санхүүжилтийн 22.1 хувийг Түнх ба доод мөчний шагай ба тавхайнаас бусад хэсгийн түлэгдэл тус тус эзэлж байна.

Хүснэгт 55. **Хүүхдийн биеийн олон хэсгийн түлэнхийн мэс заслын тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон олгосон санхүүжилт**

| №               | Хүүхдийн биеийн олон хэсгийн түлэнхийн мэс заслын тусламж, үйлчилгээний оношийн бүлэг               | Мэс заслын тоо | Санхүүжилт /сая төг/ |
|-----------------|---|----------------|----------------------|
| 1               | Биеийн олон хэсэг халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх   | 76             | 1,099.6              |
| 2               | Түнх ба доод мөчний шагай ба тавхайнаас бусад хэсгийн түлэгдэл                                      | 37             | 176.9                |
| 3               | Бугуй ба сарвуу халууны үйлчлэлээр түлэгдэх   | 16             | 15.5                 |
| 4               | Бусад дотор эрхтэн халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх  | 9              | 2.3                  |
| 5               | Түнх ба доод мөчний шагай ба тавхайны түлэгдэл  | 7              | 20.5                 |
| 6               | Их бие халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх  | 4              | 9.2                  |
| 7               | Мөрний бүслүүр ба дээд мөчний бугуй ба сарвуунаас бусад хэсэг халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх | 4              | 3.8                  |
| 8               | Толгой ба хүзүүний түлэгдэл   | 2              | 0.4                  |
| <b>Нийт дүн</b> |   | <b>155</b>     | <b>1,328.2</b>       |

Өнгөрсөн онд төрөлхийн гажиг засах мэс заслын хагалгаагаар 911 хүүхдийн, биеийн олон хэсгийн түлэнхийн мэс заслын хагалгаагаар 155 хүүхдийн амь насыг аварч, цаашлаад амьдралын чанарыг нь сайжруулсан байна.





**БҮЛЭГ**

“  
**ЭЛЭГ БҮТЭН  
МОНГОЛ**”

**ҮНДЭСНИЙ  
ХӨТӨЛБӨР**

---



## III. “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### 3.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Элэгний В, С вирусийн халдвартай тэмцэхээр Монгол Улсын Засгийн газар “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү хөтөлбөр нь 2017-2020 онд хэрэгжсэн бөгөөд 2020 он гэхэд Монгол Улсын хүн амын дунд гепатит вирусийн халдварын тархалтыг хязгаарлан, гепатит С вирусийн халдварын шинэ тохиолдлыг таслан зогсоож, гепатитийн вирусээс үүдэлтэй элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас баралтыг эрс бууруулна гэсэн зорилго тавьж, Монгол Улсын 15-аас дээш насны бүх хүн амд элэгний В, С вирусийн халдварыг эрт илрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулсан.

Уг хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 18 дугаар тогтоолоор “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг баталсан. Үүнд:

1. Элэгний В, С вирусийн анхдагч илрүүлэг шинжилгээний зардлыг 3,500 төгрөгөөр;
2. Элэгний В, С вирусийн анхдагч илрүүлэг шинжилгээний хариу сул эерэг, эргэлзээтэй гарсан тохиолдолд илрүүлгийн нэмэлт шинжилгээний зардлыг 5,000-10,000 төгрөгөөр;
3. Элэгний В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээний дээд хязгаарыг хагас автоматаар тодорхойлоход 80,000 төгрөг, бүрэн автоматаар тодорхойлоход 120,000 төгрөгөөр;
4. Элэгний D вирусийн илрүүлэг шинжилгээний зардлыг 15,000 хүртэл төгрөгөөр, идэвхжил тодорхойлох шинжилгээний төлбөрийн дээд хязгаарыг 120,000 төгрөгөөр;
5. Элэгний С вирусийн эсрэг нийлмэл найрлагатай 5 төрлийн эмэнд (Харвони, Ледвир, Гепсинат ЛП, Ледифос, Вирпас) эрүүл мэндийн даатгалаас олгох хөнгөлөлтийг 210,000 төгрөгөөр, дан найрлагатай 2 эмэнд (Майдекла 60 эмэнд 60,000 төгрөгөөр, Майхеп эмэнд 150,000 төгрөгөөр) эрүүл мэндийн даатгалаас олгох хөнгөлөлтийг 60,000-150,000 төгрөгөөр тус тус баталсан.

### 3.2 ХАМРАГДАЛТ

Хүснэгт 5б. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хэрэгжилт

| Төрөл  | 2020 оны гүйцэтгэл      |                      | 2021 оны гүйцэтгэл      |                      |
|--|-------------------------|----------------------|-------------------------|----------------------|
|  | хүний тоо / мянган хүн/ | мөнгөн дүн /сая төг/ | хүний тоо / мянган хүн/ | мөнгөн дүн /сая төг/ |
| Гепатит В, С вирусийг илрүүлэх, баталгаажуулах шинжилгээ | 125.1                   | 485.9                | 28.2                    | 58.9                 |
| Гепатит В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээ     | 37.7                    | 3,395.3              | 10.5                    | 741.0                |

|   |              |                |             |                |
|---|--------------|----------------|-------------|----------------|
| Хепатит В, С вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлт | 65.3         | 5,182.5        | 51.1        | 3,011.7        |
| <b>Нийт</b>                                       | <b>228.1</b> | <b>9,063.7</b> | <b>89.8</b> | <b>3,811.6</b> |

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрт 2021 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 3.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс хепатит В, С вирусийг илрүүлэх, баталгаажуулах шинжилгээний зардалд 58.9 сая төгрөг, хепатит В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээд 741.0 сая төгрөг, хепатит В, С вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлтөд 3.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд 2021 онд 28.2 мянган хүн хепатит В, С вирусийн илрүүлэг, баталгаажуулах шинжилгээнд хамрагдсан байна. Идэвхжил тодорхойлох шинжилгээнд 10.5 мянган хүн хамрагдаж, хепатит В вирусийн эсрэг эмийн эмчилгээнд 46.7 мянган хүн хамрагдаж, хепатит С вирусийн эсрэг эмийн эмчилгээнд 4.4 мянган хүн тус тус хамрагдсан байна.


### 3.3 ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 57. Илрүүлэх шинжилгээний хариу

| Илрүүлэх шинжилгээний хариу | В вирус       |               | С вирус       |               |
|-----------------------------|---------------|---------------|---------------|---------------|
|                             | тоо           | хувь          | тоо           | хувь          |
| Эерэг                       | 2,364         | 8.6%          | 2,052         | 7.5%          |
| Сул эерэг                   | 40            | 0.1%          | 121           | 0.4%          |
| Сөрөг                       | 25,047        | 91.0%         | 25,255        | 91.7%         |
| Эргэлзээтэй                 | 64            | 0.2%          | 75            | 0.3%          |
| Сонгоогүй                   | 20            | 0.1%          | 32            | 0.1%          |
| <b>Нийт</b>                 | <b>27,535</b> | <b>100.0%</b> | <b>27,535</b> | <b>100.0%</b> |

Элэгний В, С вирусийн илрүүлэх шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийн 8.6 хувь буюу 2,634 даатгуулагч элэгний В вирустэй, 7.5 хувь буюу 2,052 даатгуулагч элэгний С вирусийн халдвартай гэсэн шинжилгээний хариу гарсан байна. Баталгаажуулах шинжилгээнд 735 даатгуулагч хамрагдсан байна.

График 37. Илрүүлэх шинжилгээний хамрагдалт, насны бүлгээр




Илрүүлэх шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийн 66.7 хувь буюу 18,370 нь 15-39 нас, 28.7 хувь буюу 7,904 нь 40-64 нас, 4.6 хувь буюу 1,261 нь 65-аас дээш насны даатгуулагч байна.

График 38. Илрүүлэх шинжилгээний хамрагдалт, сараар



Идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийн 17.9 хувь нь 1 дүгээр сард, 13.5 хувь нь 3 дугаар сард, 12.6 хувь нь 5 дугаар сард, 9.8 хувь нь 7 дугаар сард, 7.0 хувь нь 8 дугаар сард тус тус хамрагдсан байна.

График 39. Илрүүлэх шинжилгээний хамрагдалт, аймаг, нийслэлээр



Илрүүлэх шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийн 53 хувь нь Улаанбаатар хотод, 47 хувь нь орон нутагт тус тус хамрагдсан байна.


### 3.4 ИДЭВХЖИЛ ТОДОРХОЙЛОХ ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 58. Илрүүлэх шинжилгээний хариу

| Тооллогын төрөл   | В вирус      |              | С вирус      |              | Нийт          |               |
|-------------------|--------------|--------------|--------------|--------------|---------------|---------------|
|                   | хүний тоо    | хувь         | хүний тоо    | хувь         | хүний тоо     | хувь          |
| Эхний тооллого    | 2,899        | 27.6%        | 2,897        | 27.5%        | 5,796         | 55.1%         |
| Хоёрдахь тооллого | 3,020        | 28.7%        | 1,708        | 16.2%        | 4,728         | 44.9%         |
| <b>Нийт дүн</b>   | <b>5,919</b> | <b>56.3%</b> | <b>4,605</b> | <b>43.7%</b> | <b>10,524</b> | <b>100.0%</b> |


Элэгний В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд 10,524 даатгуулагч хамрагдсанаас 56.3 хувь нь В вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд, 43.7 хувь нь С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдсан байна.

График 40. Идэвхжил тодорхойлох шинжилгээний хамрагдалт, насны бүлгээр



Идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийн 40.2 хувь нь 15-39 нас, 52.6 хувь нь 40-64 нас, 7.2 хувь нь 65-аас дээш насны даатгуулагчид байна.

График 41. Идэвхжил тодорхойлох шинжилгээний хамрагдалт, сараар



Идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийн 14.4 хувь 7 дугаар сард, 12.3 хувь 5 дугаар сард, 11.9 хувь 8 дугаар сард тус тус хамрагдсан байна.

Идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийн 95.9 хувь нь Улаанбаатар хотод, 3.5 хувь нь Орхон аймагт, 0.6 хувь нь Төв аймагт тус тус хамрагдсан байна.

### 3.5 В ВИРУСИЙН ЭСРЭГ ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ

Хүснэгт 59. В вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлт

| №               | В вирусийн эсрэг эмийн нэр    | Үнийн дээд хязгаар /1 ширхэгт/ | ЭМД-ын хөнгөлөлт /1 ширхэгт/ | Эмийн тоо ширхэг | Хувь          |
|-----------------|-------------------------------|--------------------------------|------------------------------|------------------|---------------|
| 1               | Вемлид                        | 2900                           | 2030                         | 941,907          | 63.1%         |
| 2               | Викюр                         | 1850                           | 1295                         | 232,239          | 15.5%         |
| 3               | Виркил                        | 1100                           | 770                          | 240              | 0.02%         |
| 4               | Тенофовир дизопроксил фумарат | 750                            | 525                          | 149,801          | 10.0%         |
| 5               | Хепбест                       | 1500                           | 1050                         | 30,843           | 2.0%          |
| 6               | Центаурус                     | 1170                           | 819                          | 2,820            | 0.2%          |
| 7               | Энкавир 0.5 мг                | 2040                           | 1428                         | 135,427          | 9.1%          |
| 8               | Энкавир 1 мг                  | 7300                           | 5110                         | 660              | 0.04%         |
| <b>Нийт дүн</b> |                               |                                |                              | <b>1,493,937</b> | <b>100.0%</b> |

Эрүүл мэндийн даатгалын сангаас элэгний В вирусийн эсрэг 8 төрлийн эмийн ширхэг тус бүрт 70 хувийн үнийн хөнгөлөлт үзүүлж байна. Өнгөрсөн онд В вирусийн эсрэг 1,493,937 ширхэг эмийн үнийн хөнгөлөлтөд нийт 2,245.4 сая төгрөг зарцуулсан байна.

### 3.6 С ВИРУСИЙН ЭСРЭГ ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ

Хүснэгт 60. С вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлт

| №               | С вирусийн эсрэг эмийн нэр | ЭМД-ын хөнгөлөлт /1 хайрцагт/ | Эмийн тоо ширхэг | Хувь          |
|-----------------|----------------------------|-------------------------------|------------------|---------------|
| 1               | Харвони                    | 210,000                       | 17,556           | 0.5%          |
| 2               | Вирпас                     | 210,000                       | 812              | 11.7%         |
| 3               | Зикар плас                 | 199,000                       | 17,500           | 68.2%         |
| 4               | Ледвир                     | 210,000                       | 102,174          | 0.02%         |
| 5               | Ледифос                    | 210,000                       | 28               | 4.2%          |
| 6               | Хепсинат ЛП                | 210,000                       | -                | -             |
| 7               | Майдекла 60                | 60,000                        | 6,251            | 3.7%          |
| 8               | Майхеп                     | 150,000                       | 5,546            | 11.7%         |
| <b>Нийт дүн</b> |                            |                               | <b>149,867</b>   | <b>100.0%</b> |

Эрүүл мэндийн даатгалын сангаас элэгний С вирусийн эсрэг 8 төрлийн эмийн хайрцаг тус бүрт 60,000 төгрөг, 150,000 төгрөг, 199,000 төгрөг, 210,000 төгрөгийн үнийн хөнгөлөлт үзүүлж байна. 2021 онд С вирусийн эсрэг 149,867 ширхэг эмэнд 766.3 сая төгрөгийг эмийн үнийн хөнгөлөлтөд зарцуулсан байна.



**IV**

**БҮЛЭГ**

**УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ  
ҮЗЛЭГ,  
ОНОШИЛГОО,  
ШИНЖИЛГЭЭ**

---



## IV. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭ


### 4.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ (цаашид урьдчилан сэргийлэх үзлэг гэх)-нд 2021 онд 18-аас дээш насны даатгуулагчдын 4.4 хувь буюу нийт 96,805 даатгуулагч хамрагдаж, эрүүл мэндийн даатгалын сангаас 4.4 тэрбум төгрөг олгохоор тооцсон. Үүнээс 3.4 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн байгууллагуудад олгосон.

Өмнөх онтой харьцуулахад урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо 36.9 хувиар буюу 56,350 хүнээр, санхүүжилт 32.1 хувиар буюу 2.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан нь коронавируст халдварын цар тахлын үед Эрүүл мэндийн яам болон Улсын онцгой комиссоос өгсөн чиглэл болон бүх нийтийн хөл хориотой холбоотойгоор иргэд шаардлагагүй тохиолдолд эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх явдал багассантай холбоотой.


Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 46-аас дээш насны бүлгийн даатгуулагчид өмнөх оноос 1-ээс 3 хувиар өссөн бол 18-45 насны иргэдийн хамралт буурсан үзүүлэлттэй гарчээ.

График 42. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо, 2020-2021 он, хувиар



Өнгөрсөн жил урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 96.8 мянган даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий төрийн болон хувийн хэвшлийн нийт 202 эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлжээ. Үүний 55.9 хувийг анхан шатны, 19.3 хувийг лавлагаа шатлалын улсын эрүүл мэндийн байгууллагууд, үлдэх 24.8 хувийг хувийн хэвшлийн эмнэлэг, лабораториуд тус тус эзэлж байна.

График 43. Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын тоо болон санхүүжилт, хувиар






Эрүүл мэндийн даатгалын сангаас урьдчилан сэргийлэх үзлэгт зарцуулсан нийт зардлыг насны бүлэг тус бүрээр хамрагдсан хүний тоонд харьцуулж үзэхэд нэг хүнд дунджаар 45,790 төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 61. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан хүний тоо болон санхүүжилт, насны бүлгээр

| №          | Насны бүлэг     | Хүний тоо     | Санхүүжилт /сая төг/ | Нэг хүнд ногдох зардал /төг/ | Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн баталсан төлбөрийн хэмжээ |
|------------|-----------------|---------------|----------------------|------------------------------|--|
| 1          | 18-34 нас       | 29,757        | 1,005.1              | 33,777                       | 43,000   |
| 2          | 35-45 нас       | 23,873        | 1,205.4              | 50,491                       | 73,000   |
| 3          | 46-64 нас       | 36,430        | 1,954.4              | 53,648                       | 72,500   |
| 4          | 65-аас дээш нас | 6,745         | 267.8                | 39,712                       | 49,000   |
| <b>Дүн</b> |                 | <b>96,805</b> | <b>4,432.7</b>       | <b>45,790</b>                | <b>59,375</b>  |

Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг сараар авч үзэхэд 3, 10, 11 дүгээр сард үзлэгт хамрагдсан нийт хүн амын 34.2 хувь буюу 33,109 хүн хамрагдсан нь бусад саруудтай харьцуулахад хамгийн өндөр байна. 1 дүгээр сард хамгийн бага буюу 4,870 хүн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан бол хамрагдалтын хувь хамгийн өндөр байсан 10 дугаар сард 11,561 хүн урьдчилан сэргийлэх үзлэгт тус тус хамрагджээ.

График 44. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь, сараар



## 4.2 ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭ БОЛОН ИЛРҮҮЛЭГ


2021 онд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 96,805 даатгуулагч дунджаар гурван нэр төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэж, 18 төрлийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулсан байна.

Хүснэгт 62. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдан хүний болон хийгдсэн оношилгоо, шинжилгээ

| Үзүүлэлт  | 18-34 нас | 35-45 нас | 46-64 нас | 65+ нас | Нийт    |
|---|-----------|-----------|-----------|---------|---------|
| Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо               | 29,757    | 23,873    | 36,430    | 6,745   | 96,805  |
| Оношилгоо, шинжилгээ хийлгэсэн хүний тоо (давхардсан тоогоор) | 92,291    | 108,185   | 170,489   | 19,656  | 390,621 |

Нийт хийгдсэн оношилгоо, шинжилгээний 89.0 хувь нь хэвийн (өөрчлөлтгүй/сөрөг), 4.0 хувь нь ямар нэгэн өөрчлөлттэй (ихэссэн/эерэг) гарсан бол үлдэх 7.0 хувийг онош тодруулахаар дараагийн шатлал буюу лавлагаа шатлалын эмнэлэг рүү илгээсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд хийгдсэн оношилгоо, шинжилгээгээр өөрчлөлттэй гарсан хүмүүсийн тоо нас ахих тусам нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

График 45. Урьдчилан сэргийлэх үзлэгийн оношилгоо, шинжилгээний үзүүлэлтүүд




Урьдчилан сэргийлэх үзлэгийг насны бүлэг тус бүрээр авч үзвэл:

**18-34 НАСНЫ ДААТГУУЛАГЧИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН БАГЦ**

| Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний нэр |  | Төлбөрийн хэмжээ /төг/ |
|--|--|------------------------|
| 1  | Биеийн бүрдмэл үзлэг (эмчийн үзлэг, биеийн жингийн индекс, цусны даралт хэмжих, эрсдэлийн үнэлгээний асуумж) | 10,000                 |
| 2  | БЗХӨ-ний илрүүлэг (тэмбүү, заг хүйтэн, ХДХВ илрүүлэх шинжилгээ)  | 10,000                 |
| 3  | Рентген зураг (сүрьеэ, уушигны өөрчлөлт, уушигны хавдар)   | 8,000                  |
| 4  | Хэвлийн ЭХО /элэг, цөс, нойр булчирхай, дэлүү, бөөрний өөрчлөлт/   | 15,000                 |
| <b>НИЙТ</b>  |  | <b>43,000</b>          |

Урьдчилан сэргийлэх үзлэгээр 18-34 насны даатгуулагчид биеийн бүрдмэл үзлэгээс гадна хэвлийн эхо, рентген зураг, бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг гэсэн гурван төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэсэн. Үүнээс хэвлийн эхоны оношилгоор 4.9 хувь нь өөрчлөлттэй гарсан байна.

График 46. 18-34 насны даатгуулагчийн хийлгэсэн оношилгоо, шинжилгээ




### 35-45 НАСНЫ ДААТГУУЛАГЧИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН БАГЦ

| Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний нэр |  | Төлбөрийн хэмжээ /төг/ |
|--|--|------------------------|
| 1  | Биеийн бүрдмэл үзлэг (эмчийн үзлэг, хөхний үзлэг, биеийн жингийн индекс, цусны даралт хэмжих, эрсдэлийн үнэлгээний асуумж) | 10,000                 |
| 2  | Зүрхний цахилгаан бичлэг (зүрхний үйл ажиллагааны өөрчлөлт, хэм алдагдалт)   | 8,000                  |
| 3  | Хэвлийн ЭХО /элэг, цөс, нойр булчирхай, дэлүү, бөөрний өөрчлөлт/   | 15,000                 |
| 4  | Өөх тосны солилцоо /TG, HDLP/ (судасны хананы нарийсалт, даралт ихсэх өвчнийг тодорхойлох)                                 | 12,000                 |
| 5  | Цусанд сахар үзэх (чихрийн шижин өвчнийг илрүүлэх)   | 3,000                  |
| 6  | Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг (үзлэг+ПАП/ эсийн шинжилгээ) / эмэгтэйчүүдэд/  | 15,000                 |
| 7  | Бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг (тэмбүү, заг хүйтэн, ХДХВ илрүүлэх шинжилгээ)                                     | 10,000                 |
| <b>НИЙТ</b>  |  | <b>58,000-73,000</b>   |

35-45 насны даатгуулагчид нийт 6 төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэснээс өөх тосны солилцоо болон хэвлийн эхоны оношилгоогоор хамгийн өндөр өөрчлөлттэй гарсан байна.

График 47. 35-45 насны даатгуулагчийн хийлгэсэн оношилгоо, шинжилгээ




### 46-64 НАСНЫ ДААТГУУЛАГЧИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН БАГЦ

| Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний нэр |  | Төлбөрийн хэмжээ /төг/ |
|--|--|------------------------|
| <b>Багц-I</b>  |  |                        |
| 1  | Биеийн бүрдмэл үзлэг (эмчийн үзлэг, хөхний үзлэг, биеийн жингийн индекс, цусны даралт хэмжих, эрсдэлийн үнэлгээний асуумж) | 10,000                 |
| 2  | Зүрхний цахилгаан бичлэг (зүрхний үйл ажиллагааны өөрчлөлт, хэм алдагдалт)   | 8,000                  |
| 3  | Хэвлийн ЭХО /элэг, цөс, нойр булчирхай, дэлүү, бөөрний өөрчлөлт/   | 15,000                 |
| 4  | Өөх тосны солилцоо /TG, HDLP/ (судасны хананы нарийсалт, даралт ихсэх өвчнийг тодорхойлох)                                 | 12,000                 |

|                |  |               |
|----------------|--|---------------|
| 5              | Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг (үзлэг+ПАП/ эсийн шинжилгээ) / эмэгтэйчүүдэд/  | 15,000        |
| 6              | Түрүү булчирхайн үзлэг (түрүү булчирхайн томролт) /эрэгтэйчүүдэд/  |               |
| 7              | Бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг (тэмбүү, заг хүйтэн, ХДХВ илрүүлэх шинжилгээ)                                     | 10,000        |
| <b>НИЙТ</b>    |  | <b>70,000</b> |
| <b>Багц-II</b> |  |               |
| 1              | Биеийн бүрдмэл үзлэг (эмчийн үзлэг, хөхний үзлэг, биеийн жингийн индекс, цусны даралт хэмжих, эрсдэлийн үнэлгээний асуумж) | 10,000        |
| 2              | Ходоодны дуран (улаан хоолой, ходоодны үрэвсэл, шарх, хавдрын илрүүлэг)  | 40,000        |
| 3              | Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг (үзлэг+ПАП/эсийн шинжилгээ) / эмэгтэйчүүдэд/   | 15,000        |
| 4              | Түрүү булчирхайн үзлэг (түрүү булчирхайн томролт) /эрэгтэйчүүдэд/  |               |
| 5              | Бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг (тэмбүү, заг хүйтэн, ХДХВ илрүүлэх шинжилгээ)                                     | 10,000        |
| <b>НИЙТ</b>    |  | <b>75,000</b> |

46-64 насны даатгуулагчид хамгийн олон буюу нийт 7 төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэсэн. Мөн бусад насны бүлгийн хүмүүстэй харьцуулахад энэ бүлгийн иргэд оношилгоо, шинжилгээгээр хамгийн их өөрчлөлттэй гарсан байна.

График 48. 46-64 насны даатгуулагчийн хийлгэсэн оношилгоо, шинжилгээ




**65-ААС ДЭЭШ НАСНЫ ДААТГУУЛАГЧИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН БАГЦ**

| Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний нэр |  | Төлбөрийн хэмжээ / төг / |
|--|--|--------------------------|
| <b>Багц-I</b>  |  |                          |
| 1  | Биеийн бүрдмэл үзлэг /эмчийн үзлэг, хөхний үзлэг, биеийн жингийн индекс, цусны даралт хэмжих, эрсдэлийн үнэлгээний асуумж/ | 10,000                   |
| 2  | Зүрхний цахилгаан бичлэг /зүрхний үйл ажиллагааны өөрчлөлт, хэм алдагдалт/   | 8,000                    |

|                |  |               |
|----------------|--|---------------|
| 3              | Хэвлийн ЭХО /элэг, цес, нойр булчирхай, дэлүү, бөөрний өөрчлөлт/   | 15,000        |
| 4              | Нүдний үзлэг /нүдний уг дурандах, нүдний даралт үзэх/  | 15,000        |
| <b>НИЙТ</b>    |  | <b>48,000</b> |
| <b>Багц-II</b> |  |               |
| 1              | Биеийн бүрдмэл үзлэг /эмчийн үзлэг, биеийн жингийн индекс, цусны даралт хэмжих, эрсдэлийн үнэлгээний асуумж/ | 10,000        |
| 2              | Ходоодны дуран (улаан хоолой, ходоодны үрэвсэл, шарх, хавдрын илрүүлэг)                                      | 40,000        |
| <b>НИЙТ</b>    |  | <b>50,000</b> |

65-аас дээш насны даатгуулагчид 4 төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэснээс 10-аас дээш хувь нь өөрчлөлттэй гарсан. Үүнээс хамгийн өндөр хувь нь ходоодны дурангийн оношилгоо байна.

График 49. 65-аас дээш насны даатгуулагчийн хийлгэсэн оношилгоо, шинжилгээ



Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд 2021 онд 18-аас дээш насны даатгуулагчдын 4.4 хувь буюу 96,805 даатгуулагч эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий төрийн болон хувийн хэвшлийн 202 эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн.

Цаашид хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөлтэй уялдуулж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний багцыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

**V**

**БҮЛЭГ**



# АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

## V. АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн даатгалын сангаас анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 04-р тогтоол, 2019 оны 23-р тогтоолын дагуу нэг иргэнээр тооцсон болон 4 төрлийн тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцон санхүүжилт олгосон байна.

### 5.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ 04 ДҮГЭЭР ТОГТООЛ

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг нэг иргэнээр тооцон санхүүжүүлэхдээ Үндэсний статистикийн хорооноос гаргасан тухайн нутаг дэвсгэрт албан ёсоор оршин суугаа суурин хүн ам болон тухайн баг, хороонд албан ёсоор түр оршин суух хүн амын тоонд үндэслэн суурь төсвөөр бодож олгодог.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 2021 оны байдлаар анхан шатны 535 эрүүл мэндийн байгууллагад нийт 198,7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.


*Хүснэгт 63. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нэг иргэнээр тооцож олгосон санхүүжилт, аймаг, нийслэлээр*

| №  | Аймаг, нийслэл | Эрүүл мэндийн байгууллагын тоо | Санхүүжилт /сая төг/ | Санхүүжилт /хувь/ |
|----|----------------|--------------------------------|----------------------|-------------------|
| 1  | Архангай       | 22                             | 9,444.0              | 4.8%              |
| 2  | Баян-Өлгий     | 18                             | 8,812.6              | 4.4%              |
| 3  | Баянхонгор     | 24                             | 9,504.2              | 4.8%              |
| 4  | Булган         | 18                             | 7,203.9              | 3.6%              |
| 5  | Говь-Алтай     | 22                             | 8,199.1              | 4.1%              |
| 6  | Говьсүмбэр     | 3                              | 1,024.0              | 0.5%              |
| 7  | Дархан-Уул     | 8                              | 4,026.2              | 2.0%              |
| 8  | Дорноговь      | 17                             | 5,731.4              | 2.9%              |
| 9  | Дорнод         | 16                             | 6,813.2              | 3.4%              |
| 10 | Дундговь       | 17                             | 6,129.2              | 3.1%              |
| 11 | Завхан         | 25                             | 9,188.0              | 4.6%              |
| 12 | Орхон          | 9                              | 3,088.0              | 1.6%              |
| 13 | Сэлэнгэ        | 26                             | 9,328.9              | 4.7%              |
| 14 | Сүхбаатар      | 15                             | 5,680.4              | 2.9%              |
| 15 | Төв            | 27                             | 10,041.0             | 5.1%              |
| 16 | Увс            | 22                             | 9,286.5              | 4.7%              |

|             |             |            |                  |               |
|-------------|-------------|------------|------------------|---------------|
| 17          | Улаанбаатар | 134        | 40,533.9         | 20.4%         |
| 18          | Ховд        | 21         | 7,060.9          | 3.6%          |
| 19          | Хэнтий      | 25         | 8,562.9          | 4.3%          |
| 20          | Хөвсгөл     | 28         | 12,548.4         | 6.3%          |
| 21          | Өвөрхангай  | 21         | 8,975.3          | 4.5%          |
| 22          | Өмнөговь    | 17         | 7,491.1          | 3.8%          |
| <b>Нийт</b> |             | <b>535</b> | <b>198,673.0</b> | <b>100.0%</b> |

Нийт олгосон санхүүжилтийн 20.4 хувь буюу 40.5 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын 134 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад, 79.6 хувь буюу 158.2 тэрбум төгрөгийг орон нутгийн 401 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад олгосон байна.

График 50. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нэг иргэнээр тооцож олгосон санхүүжилт, аймаг, нийслэлээр



## 5.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2019 ОНЫ 23 ДУГААР ТОГТООЛ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 23-р тогтоолын дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ гэсэн 4 төрлийн тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр заасан.

Хүснэгт 64. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлсэн 4 төрлийн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт


| № | Тусламж, үйлчилгээний төрөл | Тохиолдол |       | Санхүүжилт |       |
|---|-----------------------------|-----------|-------|------------|-------|
|   |                             | тоо       | хувь  | сая төг    | хувь  |
| 1 | Гэрээр үзүүлэх              | 60,995    | 13.7% | 5,664.2    | 37.4% |
| 2 | Оношилгоо, шинжилгээ        | 258,173   | 58.1% | 2,693.9    | 17.8% |



|                 |                 |                |               |                 |               |
|-----------------|-----------------|----------------|---------------|-----------------|---------------|
| 3               | Өдрийн эмчилгээ | 61,840         | 13.9%         | 4,235.2         | 28.0%         |
| 4               | Сэргээн засах   | 63,366         | 14.3%         | 2,542.6         | 16.8%         |
| <b>Нийт дүн</b> |                 | <b>444,374</b> | <b>100.0%</b> | <b>15,135.9</b> | <b>100.0%</b> |

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн үзүүлсэн 4 төрлийн тусламж, үйлчилгээний 444,374 тохиолдолд 15.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон байна. Үүнээс оношилгоо, шинжилгээ хамгийн өндөр буюу нийт тохиолдлын 58.1 хувь, санхүүжилтийн 17.8 хувийг эзэлж байна. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын хамгийн бага буюу 13.7 хувь, санхүүжилтийн 37.4 хувийг тус тус эзэлж байна.

График 51. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлсэн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, тусламж, үйлчилгээний төрлөөр



Нийт санхүүжилтийн 21.8 хувь буюу 3.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нийслэлийн, 78.2 хувь буюу 11.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд болох өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд олгосон байна.

Хүснэгт 65. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн 4 төрлийн тусламж, үйлчилгээний санхүүжилт (сая төг)

| №               | Аймаг, нийслэл | Гэрээр үзүүлэх | Оношилгоо, шинжилгээ | Өдрийн эмчилгээ | Сэргээн засах  | Нийт            |
|-----------------|----------------|----------------|----------------------|-----------------|----------------|-----------------|
| 1               | Улаанбаатар    | 707.5          | 612.4                | 891.5           | 498.6          | 2,710.0         |
| 2               | Орон нутаг     | 4,955.9        | 2,081.5              | 3,343.4         | 2,045.1        | 12,425.9        |
| <b>Нийт дүн</b> |                | <b>5,663.4</b> | <b>2,693.9</b>       | <b>4,234.9</b>  | <b>2,543.7</b> | <b>15,135.9</b> |


Аймгуудын анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад олгосон 4 төрлийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг задалж харвал, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээгээр Өвөрхангай аймаг, оношилгоо, шинжилгээ болон өдрийн эмчилгээгээр Хөвсгөл аймаг, сэргээн засах тусламж, үйлчилгээгээр Архангай аймаг хамгийн их санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас авсан байна.

Хүснэгт 66. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн 4 төрлийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, тусламж, үйлчилгээний төрлөөр болон аймаг, нийслэлээр

| №               | Аймаг, нийслэл | Гэрээр үзүүлэх | Оношилгоо, шинжилгээ | Өдрийн эмчилгээ | Сэргээн засах | Нийт дүн      |
|-----------------|----------------|----------------|----------------------|-----------------|---------------|---------------|
| 1               | Архангай       | 4.3%           | 5.2%                 | 4.0%            | 6.2%          | 4.7%          |
| 2               | Баян-Өлгий     | 1.9%           | 2.3%                 | 6.7%            | 2.9%          | 3.5%          |
| 3               | Баянхонгор     | 7.3%           | 6.0%                 | 5.4%            | 3.8%          | 6.0%          |
| 4               | Булган         | 2.7%           | 2.9%                 | 3.4%            | 1.6%          | 2.7%          |
| 5               | Говь-Алтай     | 1.7%           | 1.5%                 | 2.1%            | 1.4%          | 1.7%          |
| 6               | Говьсүмбэр     | 0.3%           | 0.4%                 | 0.2%            | 0.4%          | 0.3%          |
| 7               | Дархан-Уул     | 1.5%           | 3.9%                 | 2.5%            | 4.5%          | 2.7%          |
| 8               | Дорноговь      | 4.1%           | 1.5%                 | 3.9%            | 4.6%          | 3.7%          |
| 9               | Дорнод         | 2.5%           | 2.4%                 | 2.9%            | 3.4%          | 2.7%          |
| 10              | Дундговь       | 1.1%           | 1.7%                 | 2.2%            | 2.2%          | 1.8%          |
| 11              | Завхан         | 2.9%           | 3.1%                 | 2.3%            | 1.2%          | 2.5%          |
| 12              | Орхон          | 4.4%           | 2.8%                 | 3.6%            | 4.5%          | 3.9%          |
| 13              | Өвөрхангай     | 11.4%          | 5.9%                 | 5.9%            | 6.3%          | 8.0%          |
| 14              | Өмнөговь       | 2.5%           | 3.1%                 | 2.0%            | 2.3%          | 2.4%          |
| 15              | Сүхбаатар      | 4.6%           | 1.8%                 | 2.6%            | 3.6%          | 3.4%          |
| 16              | Сэлэнгэ        | 2.3%           | 5.9%                 | 3.5%            | 2.9%          | 3.4%          |
| 17              | Төв            | 8.2%           | 5.7%                 | 4.0%            | 6.0%          | 6.2%          |
| 18              | Увс            | 3.1%           | 4.2%                 | 4.2%            | 5.2%          | 4.0%          |
| 19              | Улаанбаатар    | 12.8%          | 23.7%                | 22.1%           | 20.5%         | 18.6%         |
| 20              | Ховд           | 9.4%           | 5.2%                 | 3.7%            | 5.0%          | 6.3%          |
| 21              | Хөвсгөл        | 5.7%           | 8.2%                 | 8.6%            | 6.2%          | 7.0%          |
| 22              | Хэнтий         | 5.3%           | 2.6%                 | 4.2%            | 5.3%          | 4.5%          |
| <b>Нийт дүн</b> |                | <b>100.0%</b>  | <b>100.0%</b>        | <b>100.0%</b>   | <b>100.0%</b> | <b>100.0%</b> |

Өнгөрсөн онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн 4 төрлийн тусламж, үйлчилгээг сараар авч үзвэл 3 дугаар сард хамгийн их санхүүжилт олгосон нь нийт санхүүжилтийн 11.4 хувийг эзэлж байна. Харин 6 дугаар сард хамгийн бага буюу нийт санхүүжилтийн 4.5 хувийг олгосон байна.

График 52. Дөрвөн төрлийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, сараар



Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн үзүүлсэн 4 төрлийн тусламж, үйлчилгээний нийт тохиолдлын 40.4 хувийг 55-аас дээш насны даатгуулагчид, үлдэх хувийг бусад насны даатгуулагчид эзэлж байна. Нас ахих тусам анхан шатны тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо нэмэгдсэн байна.

Хүснэгт 67. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлсэн 4 төрлийн тусламж, үйлчилгээ, насны бүлгээр

| №               | Насны ангилал   | Тохиолдол      |               | Санхүүжилт      |               |
|-----------------|-----------------|----------------|---------------|-----------------|---------------|
|                 |                 | тоо            | хувь          | сая төг         | хувь          |
| 1               | 00-19 нас       | 38,054         | 8.6%          | 1,185.3         | 7.8%          |
| 2               | 20-24 нас       | 19,288         | 4.3%          | 447.6           | 3.0%          |
| 3               | 25-29 нас       | 27,327         | 6.1%          | 694.0           | 4.6%          |
| 4               | 30-34 нас       | 35,939         | 8.1%          | 911.7           | 6.0%          |
| 5               | 35-39 нас       | 34,753         | 7.8%          | 921.5           | 6.1%          |
| 6               | 40-44 нас       | 32,325         | 7.3%          | 963.8           | 6.4%          |
| 7               | 45-49 нас       | 35,964         | 8.1%          | 1,169.4         | 7.7%          |
| 8               | 50-54 нас       | 41,296         | 9.3%          | 1,434.8         | 9.5%          |
| 9               | 55-59 нас       | 48,186         | 10.8%         | 1,793.0         | 11.8%         |
| 10              | 60-64 нас       | 47,025         | 10.6%         | 1,840.3         | 12.2%         |
| 11              | 65-аас дээш нас | 84,218         | 19.0%         | 3,774.5         | 24.9%         |
| <b>Нийт дүн</b> |                 | <b>444,374</b> | <b>100.0%</b> | <b>15,135.9</b> | <b>100.0%</b> |

# VI БҮЛЭГ



## ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ

---



## VI. ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтад багтсан 141 ерөнхий нэршлийн 574 худалдааны нэрийн эмэнд эрүүл мэндийн даатгалын сангаас 30-70 хувийн үнийн хөнгөлөлт олгож, гэрээ бүхий эмийн сангуудад эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилт олгосон байна.

Өнгөрсөн оны байдлаар 510 нэрийн эмэнд 60.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулсан эмийн сангуудад олгосон байна.

### Хүснэгт 68. Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймаг, нийслэлээр

| №           | Аймаг, нийслэл    | Санхүүжилт /сая төг/ | Хувь          |
|-------------|-------------------|----------------------|---------------|
| 1           | Улаанбаатар       | 30,582.4             | 50.6%         |
| 2           | Аймаг, орон нутаг | 29,817.6             | 49.4%         |
| <b>Нийт</b> |                   | <b>60,400.0</b>      | <b>100.0%</b> |


Эндээс харахад эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөлт үзүүлсэн санхүүжилт нь нийслэл болон орон нутагт ойролцоо байна.

### Хүснэгт 69. Нийслэлийн дүүргүүдийн эмийн сангуудад олгосон санхүүжилт

| №           | Дүүрэг         | Гэрээ байгуулсан эмийн сангийн тоо | Санхүүжилт      |               |
|-------------|----------------|------------------------------------|-----------------|---------------|
|             |                |                                    | сая төг         | хувь          |
| 1           | Баянгол        | 166                                | 5,723.5         | 19.2%         |
| 2           | Баянзүрх       | 215                                | 6,779.8         | 22.8%         |
| 3           | Сонгинохайрхан | 121                                | 4,526.9         | 15.3%         |
| 4           | Сүхбаатар      | 105                                | 4,022.0         | 13.5%         |
| 5           | Хан-Уул        | 137                                | 4,006.4         | 14.5%         |
| 6           | Чингэлтэй      | 71                                 | 3,122.6         | 10.5%         |
| 7           | Багануур       | 10                                 | 696.8           | 2.4%          |
| 8           | Налайх         | 13                                 | 539.6           | 1.8%          |
| <b>Нийт</b> |                | <b>838</b>                         | <b>29,817.6</b> | <b>100.0%</b> |

Нийслэлийн хэмжээнд нийт 838 эмийн сан хөнгөлөлттэй эмийн жороор даатгуулагчдад үйлчилж, 29.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас авсан байна. Байршлаар нь харахад Баянзүрх дүүрэгт байрлалтай эмийн сангууд хамгийн өндөр буюу санхүүжилтийн 22.8 хувийг, харин Налайх дүүрэгт байрлалтай эмийн сангууд хамгийн бага буюу 1.8 хувийн санхүүжилтийг тус тус авсан байна.

График 53. Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймгаар




Аймаг, орон нутгаар нь харахад Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул аймгийн эмийн сангууд бусад аймгуудтай харьцуулахад өндөр санхүүжилт авсан байна.

Хүснэгт 70. Өндөр дүнтэй санхүүжилт авсан аймгууд

| № | Аймаг      | Суурин хүн амын тоо | Гэрээ байгуулсан эмийн сангийн тоо | Санхүүжилт |      |
|---|------------|---------------------|------------------------------------|------------|------|
|   |            |                     |                                    | сая төг    | хувь |
| 1 | Баян-Өлгий | 108,376             | 53                                 | 3,793.2    | 6.3% |
| 2 | Орхон      | 104,737             | 67                                 | 2,713.2    | 4.5% |
| 3 | Дархан-Уул | 106,145             | 53                                 | 1,875.0    | 3.1% |

График 54. Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, сараар



Нийт санхүүжилтийн хамгийн их буюу 8.0 тэрбум төгрөгийг 7 дугаар сард, хамгийн бага буюу 2.5 тэрбум төгрөгийг 2 дугаар сард гэрээ бүхий эмийн сангуудад тус тус олгосон байна.


Хүснэгт 71. ЭМДС-аас хөнгөлөлттэй олгосон эмийг өвчний бүлгээр

| № | Эмийн бүлэг                                 | Санхүүжилт |      |
|---|---|------------|------|
|   |   | сая төг    | хувь |
| 1 | Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эм | 332.3      | 0.6% |

|             |  |                 |               |
|-------------|--|-----------------|---------------|
| 2           | Арьсны өвчнийг эмчлэх бэлдмэл  | 7.5             | 0.01%         |
| 3           | Бөөр, шээсний замд нөлөөлөх эм   | 933.6           | 1.5%          |
| 4           | Вирусийн эсрэг бэлдмэл   | 95.1            | 0.2%          |
| 5           | Даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл | 4047.9          | 6.7%          |
| 6           | Дархлаа дарангуйлах эм   | 155.4           | 0.3%          |
| 7           | Зүрх судасны эм  | 30374.6         | 50.3%         |
| 8           | Нүдний өвчинд хэрэглэх бэлдмэл   | 282.1           | 0.5%          |
| 9           | Окситоцин ба түүний эсрэг бэлдмэлүүд                                     | 89.9            | 0.1%          |
| 10          | Опиодын буюу наркотик өвдөлт намдаах эм                                  | 0.7             | 0.001%        |
| 11          | Өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг эм                     | 1306.1          | 2.2%          |
| 12          | Салга өвчнийг эмчлэх эм /паркинсоны өвчин/                               | 39.1            | 0.1%          |
| 13          | Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм                            | 3560.4          | 5.8%          |
| 14          | Түүрүү булчирхайн эмгэгт хэрэглэх эм                                     | 7.2             | 0.01%         |
| 15          | Уналт, таталтын эсрэг эм   | 1757.9          | 2.9%          |
| 16          | Халдварын эсрэг бэлдмэл  | 2965.4          | 4.9%          |
| 17          | Харшлын ба анафилаксийн эсрэг эм   | 72.6            | 0.1%          |
| 18          | Ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм                                 | 9439.3          | 15.6%         |
| 19          | Цусанд нөлөөлөх эм   | 4813.7          | 8.0%          |
| 20          | Чихрийн шижин эмчлэх   | 119.0           | 0.2%          |
| <b>Нийт</b> |  | <b>60,400.0</b> | <b>100.0%</b> |


Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгосон нийт эмийн 50.3 хувь нь зүрх судасны үйл ажиллагааны алдагдал, 15.6 хувь нь хоол боловсруулах замын үйл ажиллагааны алдагдлын үед хэрэглэх бэлдмэл, 6.7 хувь нь дааврын гаралтай бэлдмэл, 4.9 хувь нь халдварын эсрэг бэлдмэл, 2.9 хувь нь уналт таталтын эсрэг бэлдмэл, 5.8 хувь нь сэтгэц нөлөөт эмийн бэлдмэл байгаа бол 8.0 хувийг цусанд нөлөөлөх эмийн бэлдмэл, 2.2 хувийг өвдөлт намдаах эмийн бэлдмэл, 1.5 хувийг бөөр шээсний замын эмгэгийн үед хэрэглэх эмийн бэлдмэлүүд тус тус эзэлж байна.

График 55. Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт даатгуулагчийн төрлөөр



Даатгуулагчийн төрлөөр нь авч үзэхэд тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд хөнгөлөлттэй эмийн нийт санхүүжилтийн 72.9 хувийг эзэлж байгаа бол хугацаат цэргийн албан хаагч, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн, ял эдэлж байгаа ялтан санхүүжилтийн хамгийн бага хувийг эзэлж байна.

График 56. Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчид, насны бүлгээр



Хөнгөлөлттэй эмийн хэрэглээг насны бүлгээр нь харахад 65-аас дээш насны хүн амын хөнгөлөлттэй эмийн хэрэглээ өндөр байгаа нь харагдаж байна. Энэ нь тэтгэврийн насны хүн амын дунд зонхилон тохиолдох зүрх, судасны өвчлөл, мэдрэлийн гаралтай өвчлөл, бөөр шээсний замын өвчлөл, хоол боловсруулах замын өвчлөл зэрэг архаг өвчин өндөр байдагтай холбоотой юм.

График 57. 00-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан эмийн хэрэглээ, эмийн өвчний бүлгээр





00-19 насны даатгуулагчдын хувьд халдварын эсрэг бэлдмэл хамгийн өндөр буюу 44.5 хувь, уналт, таталтын эсрэг эм 21.6 хувь, вирусийн эсрэг эм 9.6 хувийг эзэлж байна. Халдварын эсрэг бэлдмэлийн хэрэглээ өндөр байгаа нь бага насны хүүхдүүдийн дунд амьсгалын замын өвчлөл буюу томуу томуу төст өвчин, арьсны идээт ба мөөгөнцөрт өвчнүүд их байдагтай холбоотой. 00-19 насны даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалаас хамгийн өндөр санхүүжилт авсан дараах 5 бүлгийн эм, бэлдмэлүүд дотроос хамгийн их хэрэглээнд гарсан эмийг худалдааны нэршлээр нь харууллаа.

**Хүснэгт 72. 00-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан халдварын эсрэг эмийн тоо болон олгосон санхүүжилт**

| №  | Эмийн худалдааны нэр    | Олгосон эмийн тоо |       | Санхүүжилт |       |
|----|-------------------------|-------------------|-------|------------|-------|
|    |                         | ширхэг            | хувь  | сая төг    | хувь  |
| 1  | Амоксиклав 250мг        | 56,972            | 14.7% | 66.6       | 26.2% |
| 2  | Клавомид 375 250мг      | 62,871            | 16.2% | 52.6       | 20.7% |
| 3  | Флемоксин солутаб 250мг | 163,886           | 42.3% | 48.5       | 19.1% |
| 4  | Леводенк 250 250мг      | 10,822            | 2.8%  | 17.9       | 7.1%  |
| 5  | Моксиклав 250мг         | 10,727            | 2.8%  | 11.6       | 4.6%  |
| 6  | Кмоксилин 250мг         | 12,015            | 3.1%  | 7.0        | 2.7%  |
| 7  | Теоклав-375 250мг       | 9,048             | 2.3%  | 6.3        | 2.5%  |
| 8  | Фромилид 500мг          | 1,976             | 0.5%  | 4.5        | 1.8%  |
| 9  | Амоксициллин 250мг      | 15,282            | 3.9%  | 4.3        | 1.7%  |
| 10 | Леваксела 250мг         | 2,563             | 0.7%  | 3.4        | 1.3%  |

**Хүснэгт 73. 00-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан уналт, таталтын эмийн тоо болон олгосон санхүүжилт**

| №  | Эмийн худалдааны нэр        | Олгосон эмийн тоо |       | Санхүүжилт |       |
|----|-----------------------------|-------------------|-------|------------|-------|
|    |                             | ширхэг            | хувь  | сая төг    | хувь  |
| 1  | Депакин хроно               | 64,774            | 27.2% | 59.4       | 48.2% |
| 2  | Эпилиптор ср 200мг          | 69,458            | 29.1% | 24.3       | 19.7% |
| 3  | Матеве                      | 14,394            | 6.0%  | 21.0       | 17.0% |
| 4  | Карбамазепин                | 78,825            | 33.1% | 12.5       | 10.1% |
| 5  | Тебантин 300мг              | 2,730             | 1.1%  | 1.8        | 1.5%  |
| 6  | Валептик 250мг/5мл - 120 мл | 101               | 0.0%  | 1.6        | 1.3%  |
| 7  | Кепрептол ср 500мг          | 1,280             | 0.5%  | 0.8        | 0.6%  |
| 8  | Барбитал 5мг                | 3,262             | 1.4%  | 0.8        | 0.6%  |
| 9  | Трилептал                   | 545               | 0.2%  | 0.2        | 0.2%  |
| 10 | Опипентин 300мг             | 200               | 0.1%  | 0.2        | 0.1%  |

